

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-33

1. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/ 4-7

2. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 7-33

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 33 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, С.Бямбацогт;

Чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан;

Тасалсан: Н.Алтанхуяг.

Нэг.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүйн, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Н.Отгончимэг, Б.Ундрах, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд, Нээлттэй нийгэм форумын менежер П.Бадамрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат, Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Н.Отгончимэг, Б.Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн хуралдааныг 13 цаг 32 минутаас 13 цаг 35 минутад даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Д.Цогтбаатар: Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
12 цаг 33 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Би ирцэд байгаа гишүүдийн нэрсийг дуудаж танилцуулъя.

Ганибалын Амартүвшин гишүүн, Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн, Дашидондогийн Ганбат гишүүн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, тэгээд Дамдины Цогтбаатар гээд 52 хувийн ирцтэйгээр бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал руугаа оръё. Өнөөдрийн хуралдаанаар төлөвлөсөн ёсоор 2 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэг нь Улсын Их Хурлын ерөнхий хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Хоёр дахь нь Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг ярина.

Энэ хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа.

Улсын Их Хурлын ерөнхий хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. 1 ч гишүүн, асуух асуулттай гишүүд алга байна. Тэгье. Энэ чинь зөвхөн асуулт, санал хэлэх гишүүд байгаа юу. Тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд нэрээ өгнө үү. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ бодвол хэлэлцүүлэг зохион байгуулсан гишүүд, ажлын хэсгийнхэн энэ тогтоолын төслийг боловсруулсан байх тийм үү. Мөнхцэцэг гишүүн эд нар. Энэ хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх талаар гэдэг асуудлаар бид нар их яриагүй шүү дээ. Хууль дутуудаа гэж эсвэл хууль буруугаас, хууль хийдэлтэйгээс болж хүүхдийн эрх зөрчигдөөд байна, эсвэл төрийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдоод байна гэж бид нар яриагүй шүү дээ. Бид нар уул нь хуулиа хэрэгжүүлэх асуудал дээр уялдаа, тэгээд хүний нөөцийг төвлөрүүлэх тэр хороод дээр ажиллаж байгаа багуудад төрийн бус байгууллагынхны оролцоог нэмэгдүүлэх тэр чиглэлээр л илүү ярьсан шүү дээ. Тэгээд хамгийн түрүүнд аливаа хуулийн хэрэгжилтийг ярихлаар л хуулиа шинэчил гээд л ороод ирэхлээр чинь батлаад, хэрэгжиж ядаж байгаа хуулиа дахиад шинэчилчихлээр чинь хэрэгжилт дээр нь хүндрэл гараад байгаа байхгүй юу. Ерөөсөө асуудал ярихлаар л Засгийн газар нь ч, сайд нар нь ч Их Хурлын гишүүд нь ч бид нар ерөөсөө л хууль

болохгүй байна л гэж л нийгэмд ойлголт өгөх гээд байдаг. Тэгээд л хуулиа сайжруулчихвал бүх юм болчихно гэж бодоод байдаг. Тийм биш шүү дээ. Байгаа хуулиа хэрэгжүүлэхгүй зохион байгуулалт муутай байгаад байгаа учраас энэ 1 дүгээр заалтыг би хасах саналтай байна.

Тэр гол бидний ярьсан юм энэ багуудад ажиллаж байгаа, хороодод ажиллаж байгаа тэр хүүхдийн эрхийг хамгаалах баг байна шүү дээ. Тэр багт чинь хэсгийн төлөөлөгч, өрхийн эмч, нийгмийн ажилтан гээд дандаа тус тусдаа ажилтай хүмүүс орчихлоор тэр хүмүүс чинь энэ ажлаа ч хийж чадахгүй, өөрийнхөө ажил дээр ч анхаарлаа төвлөрүүлж чадахгүй. Бидний хүүхэд хамгаалах ажлын чинь гол суурь нь болохлоор тэр баг болчихоод байгаа байхгүй.

Тэгэхлээр тэр багаа үнэхээр жинхэнэ утгаар нь ажиллуулъя гэх юм бол тэр багийг өөр давхар ажил, үндсэн ажил эрхлээд явж байгаа хүмүүсээр биш хүүхдийн эрхийн байцаагч, тэгээд ТББ-ын оролцоо энэ 2 дээр суурилж хийлгээ л гэсэн гол санаа явсан шүү дээ. Тэрийгээ л энэнээсээ тусгачихмаар байх юм. Тэр, энэ санаа бол энэ хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэх талаар гэдэг дээр орчихоод байгаа юм. Энийгээр бол болж байгаа юм.

Хоёр дахь нь энэ танин сурталчлах талаар гэж байгаа юм. Энэ нь болж байгаа юм. Эхнийхийг нь би хасах саналтай байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүн тайлбар хэлье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Их Хурлаас гарах тогтоол дээр маань энэ хүүхэд хамгаалалттай холбоотой эрх зүйн шинэчлэл ер нь зайлиггүй орох болчихоод байгаа юм. Яагаад вэ гэхээр яг энэ цаг мөчид манай Улсын Их Хурал дээр хүүхэд хамгааллын хууль, төсөл өргөн баригдсан орж ирж байна. Энэ

дээр бид нар манай Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хорооноос хүүхдийн эрхтэй холбоотой тодорхой заалтууд зайлиггүй энэ ажлын хэсгийн дээр нэмж оруулах байгаа.

Тухайлбал, хүний эрхийн мэдрэмжтэй төсөвлөлт, хүүхдийн эрхийн мэдрэмжтэй төсөвлөлт, тэгээд шаардлагатай бол боловсролын хуульдаа ч гэсэн нэмэлт бас оруулах ер нь боломжтой байгаад байгаа. Тухайлбал энэ дээр хүний эрхийн мэдрэмжтэй сургалт, хүний эрхийн сургалт, хүүхдийн эрхийн боловсролын асуудлыг яг одоо манай холбогдох боловсролын сурах бичиг, хөтөлбөрүүдэд ер нь уях шаардлагатай. Өөрөөр хэлбэл зөвхөн хүүхэд хамгаалал гэдгээр бид нар явцуураад энэ чиглэлийн механизм, эрх зүйн зохицуулалт гэхээсээ илүү ер нь хүүхдийн эрх гэдэг өргөн хүрээтэй хүүхдийн эрхийн бүхий л асуудлаар авч үзэх шаардлагатай гэдэг дээр яг сонсгол дээр маш олон экспертүүд, мэргэжилтнүүд хэлсэн.

Тийм учраас зөвхөн хүүхэд хамгаалал дээр явцуурахгүйгээр шаардлагатай бас зарим хуулиуд дээр ер нь өөрчлөлт оруулаад явах нь зүйтэй гэдэг утгаар энэ хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх гэдэг энэ маань орсон байгаа.

Тэгээд энэ яг хамтарсан баг тэр мэргэжлийн болгох, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, холбоотой энэ заалтууд ер нь бас хуульд орж байж явах нь зүйтэй болов уу. Үүний цаана бас нэг агуулга нь Гэр бүлийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын хуулийн аль алин дээр хүүхдийн эрхтэй холбоотой заалтуудыг илүү хүчтэй тод оруулъя гэдгээр энэ нэг дэх хууль, эрх зүйн орчин гэдэг маань ер нь орсон байгаа.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүн ээ. Нээрээ энэ дээр таны яг асуусан энэ хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэхтэй холбогдуулаад Мөнхцэцэг гишүүнд нээрээ хандаад нэг хэлэх юм ийм байна л даа. Та нар тэр дээрээ энийг

яриагүй гэж байна шүү дээ. Тэгээд яриагүй байж оруулаад ирсэн юм биш биз дээ нэг.

Хоёрт, зүгээр миний зүгээс бол хэлэх зүйл ийм юм байна. Одоо энэ Баярсайхан гишүүний өргөн барих гээд би боловсруулаад явж байгаа гэж ойлгож байгаа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль гээд явж байгаа шүү дээ тийм үү. Яамны өргөн барьсан хууль байгаа бил үү тээ. Түүн дээр чинь, сая өргөн барьчихсан уу тээ. Аан за тэгэхлээр тэр хууль дээр нэг яриаар байгаа юм энэ сайбер /cyber/ орчинд хүүхдийн сэтгэхүй, хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл явах, ялангуяа оюун санааны дарамт, хүчирхийлэл явах энэ тал дээр нэлээн хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлага бол байгаа.

Тэгэхлээр тэр утгаараа Мөнх-Оргил гишүүн ээ хууль, эрх зүйн орчныг өөрчилнө гэдэг нь одоо яригдаж байгаа тэр хууль дээр жишээлбэл одоогоос яриад оруулаад та яг энэ ажлынхаа үр дүнг Баярсайхан гишүүнтэй очиж ярьж байгаад энэ юмнуудаа тусгахаар ярих юм бол энэ чинь хууль, эрх зүйн орчныг тэр бэхжүүлэх, сайжруулах агуулгадаа ороод явчихна шүү дээ.

Өөрөөр хэлбэл одоо байгаа нь бас боломжийн байж болно. Тэгэхдээ шинэ хууль гараад явж байна гэдэг чинь энэ хууль, эрх зүйн орчин чинь угаасаа л өөрөө хөгжлийнхөө явцад л явж байгаа. Тэгвэл тэн дээр ахиад сайжруулах юм байж болохоор байна шүү дээ. Тэгж ойлгоод явж болох уу Мөнх-Оргил гишүүн ээ. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Миний яриад байгаа юм чинь яг л энэ байгаа байхгүй юу. Энэ 1 дүгээр зүйл байсан, байгаагүй Засгийн газраас хуулийн төсөл өргөн баригдаад л явж байгаа, Их Хурал хуулиа хэлэлцээд л явж байгаа байхгүй юу. Бид нар энэ хэлэлцүүлэг хийсний үр дүнд энэ чинь зүгээр л хуулиа сайжруул гэдэг женерик тодорхой юм байхгүй

байгаа байхгүй юу. Бид нар хэлэлцүүлэг хийсний үр дүнд маш тодорхой зөвлөмж өгмөөр байгаа байхгүй юу. Жишээ нь байна шүү дээ Мөнхцэцэг гишүүн ээ миний санааг ойлгож байна уу та. Бид нар тэртээ тэргүй хийж байгаа ажлыг л энэнээсээ дурдаад байгаа байхгүй юу. Угаасаа хийгдэж байх ёстой юмыг л яриад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт яах гэж хэлэлцүүлэг хийх юм бэ. Хэлэлцүүлэг хийсний ач, үр дүнд бид нар маш тодорхой зөвлөмжүүдийг өгөх ёстой байхгүй юу. Тодорхой даалгавар өгмөөр байгаа байхгүй юу. Жишээ нь байгууллагууд байна шүү дээ ажилтнуудаа зориулаад, ажилтныхаа хүүхдүүдэд зориулаад цэцэрлэг, ясли байгуулчихъя гэж бодъё. Тэрэнд нь татвар ноогдох орлогоос нь хасаж тооцдог, татварын хөнгөлөлт үзүүлэх ёстой байхгүй юу. Тийм даалгавар өгөх ёстой байхгүй юу. Энийг өргөн барьж орж ир ээ тэгэх юм бол байгууллагууд чинь манай Их Хурлын Тамгын газраас авхуулаад л хажуудаа 1 жижигхэн цэцэрлэг, ясли байгуулаад энэ цэцэрлэг, ясли жинхэнэ утгаараа хүүхэд хамгаалж байгаа асуудал чинь наадах чинь байхгүй юу. Тэрнээс биш тэнд хүний эрхийн мэдрэмжтэй төсөв батална, эсвэл хүний эрхийн мэдрэмжтэй сургуулийн боловсролын хууль батална гэж ойлгомжтой шүү дээ. Угаасаа тэр чинь яригдаж байгаа. Энэ тодорхой юмнуудыг л хийх ёстой гэж л хэлээд байгаа шүү дээ. Эсвэл сургууль цэцэрлэгт яг хэрэгтэй байгаа хандивыг нь өргөчихвөл тэрэнд нь хөнгөлөлт орж байдаг, татварын хөнгөлөлт орж байдаг.

Эсвэл энэ сургууль, цэцэрлэгийн хүүхдийн өдрийн хоолон дээр нь дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжүүдэд тодорхой бид нар Засгийн газарт үүрэг өгөх ёстой байхгүй юу. Аймгийн Засаг дарга нарыг дайчлан ажиллаа, орон нутгийн жижиг, дунд бизнесүүдийг дайчил аа. Тэндээ ногоо тариад, тэр ногоогоо энэ хүүхдүүдийн цэцэрлэг, сургуулийн хоолонд өгч бай. Тэрнээс биш Улаанбаатараас юм уу Хятадаас ногоо

зөөгөөд байх биш. Иймэрхүү тодорхой ажлыг л бид нар энэ хэлэлцүүлгийн үр дүнд Засгийн газарт үүрэг болгох ёстой байхгүй юу. Тэрнээс биш хуулиа сайжруул гэдэг юм биччихээд тэгээд одоо бид нар хэлэлцүүлэг хийчихлээ гэхлээр чинь хайран цаг байгаа байхгүй юу даа. Ямар илүүдээ гарсан цагтай болчихоод хэдүүлээ энд ийм ерөнхий үүрэг, даалгавар өгөөд суугаад байх юм бэ. Энийг л би хэлээд байгаа байхгүй юу.

Одоо яг үүгээр чинь Засгийн газар байна шүү дээ яг тодорхой арга хэмжээ авъя гээд тэгэх юм бол Засгийн газар тэнд чинь хийх юм нэг ч байхгүй. Ядаж саяынхаа хэлэлцүүлгээр хэдүүлээ байгууллагынхаа дэргэд цэцэрлэг, ясли юм уу цэцэрлэг байгуулж байгаа бол татварыг нь хөнгөл, байгууллагын дэргэдэх цэцэрлэгүүдийн стандартыг нь өөрчил. Энэ чинь аягүй хүнд стандарттай байхгүй юу. Цэцэрлэг байгуулах арга байхгүй. Заавал ийм ч гарцтай, тийм ч юутай, төдөн хоолойтой гээд байгууллагууд ерөөсөө 5, 6 хүүхэдтэй цэцэрлэг ч гэсэн байвал байж болохоор байхгүй юу. Тэгэхдээ үгүй заавал 200-300 хүүхэдтэй юм уу, 100 гаруй хүүхэдтэй болж байж л цэцэрлэг болно гээд ойлгочихсон гэх мэтийн амьдралд нийцэхгүй маш олон тодорхой юмнууд байна шүү дээ тийм ээ. Эд нарыхаа л хэдүүлээ нэг нэгээр нь зааж өгөөд баймаар байгаа байхгүй юу даа. Ийм л юм яриад байгаа юм. Тэрнээс биш хууль сайжруулах ажил угаасаа хэлэлцүүлэгтэй, хэлэлцүүлэггүй хийнэ шүү дээ тэр чинь. Тэртээ тэргүй гишүүд нь хуулиа өргөн барьчихсан байж байгаа.

Одоо хэдэн байцаагч нарынхаа хэдэн нийгмийн ажилтай асуудлаараа бид нар яагаад ч энэ олон нийтийн асуудал шийдэхгүй шүү дээ.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр сая Мөнх-Оргил сайдын ярьсан санаануудыг энэ 1 дүгээр зүйлдээ энэ чинь бэхжүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, сайжруулах тал дээр яг тодорхой бас саналууд байж

байна шүү дээ. Жишээлбэл цэцэрлэгтэй холбогдсон.

Тэгэхлээр энэ юмнуудаа та нар найруулгадаа эндээ оруулаад сайжруулаад явах хэрэгтэй. Энэ тогтоолыг тийм учраас дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

90 хувиар санал дэмжигдлээ.

Энэ тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг гишүүн өөрөө ороод танилцуулчих. Хоёр дахь асуудал руугаа орёе.

12.50 цаг

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдад микрофон өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Дээд шүүхтэй зөвшилцөн боловсруулж ирүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд хүргэн мэдүүлсэн.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдох суурь судалгаа болон Улсын дээд шүүхтэй хамтран баталсан шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг тус тус үндэслэн боловсруулсан.

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж шүүхийн шатлалын үндсэн тогтолцоог хөндөхгүйгээр шүүхийн харьяалал байрших газар зохион байгуулалтыг өөрчлөх замаар иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, хүний эрхийг хангах, иргэнд үзүүлэх шүүхийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бүтээмжтэй, үр нөлөөтэй анхан болон давж заалдах шатын шүүх байгуулахаар зорилоо.

Хуулийн төсөлд анхан болон давж заалдах шатын шүүхийг байгуулах дараах зарчмын өөрчлөлтийг тусгасан болно.

1. Анхан шатын шүүхийн тухайтад

Дүүргийн анхан шатын шүүхийн тухайтад эрүүгийн хэргийн тойргийн 3, иргэний хэргийн тойргийн 3 буюу тойргийн нийт 6 шүүхийг өөрчлөн байгуулж, нутаг дэвсгэрийн алслагдмал байдлыг харгалзан Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн одоогийн зохион байгуулалтыг хэвээр үлдээхээр, Багахангай, Налайх дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатын шүүхийг тойргийн зарчмаар байгуулж, Налайх дүүрэгт байршуулахаар тусгалаа.

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатын тойргийн шүүх нийслэлийн хэмжээнд 1 байгуулахаар тусгаж, энэхүү шүүх нь мөрдөн шалгах ажиллагаа дахь шүүхийн хяналтыг сайжруулах, хүний эрхийг

хамгаалах асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай процессоор хэрэгждэг тодорхой ажиллагаануудыг болон бага үнийн дүнтэй иргэний хэрэг, зөрчлийн хэргийг харьяалан шийдвэрлэхээр. Ингэснээр дүүргийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатын шүүхийн ачаалал 30-40 хувь багасаж зохист хэмжээнд очно гэж үзсэн болно.

Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүхийг нийслэлийн хэмжээнд 1 байгуулахаар тусгаж, энэ төрлийн шүүхийг байгуулснаар дүүргийн эрүүгийн болон Иргэний хэргийн анхан шатын шүүхийн ажлын ачаалал 15-20 хувь багасахаар байна гэж бид үзэж байна.

Харин орон нутагт гарч байгаа хэргийн тоо, төрлийг харгалзан энэ төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ тусдаа шүүх байгуулах шаардлагагүй гэж үзэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар орон нутаг дахь анхан шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байх асуудал нь нээлттэй гэж үзсэн болно.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүх болон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатын нийт 22 шүүх тэдгээрийн байршлыг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар тогтоосны дагуу хэвээр үлдээлээ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүх байгуулах тухай хуулийн дагуу байгуулсан 21 аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатын 21, Эрүүгийн хэргийн анхан шатын 21, нийт 42 шүүхүүдийг зохион байгуулалтын хувьд нэгтгэж, шүүхийн ажил үүргийн хувиар орон тоог оновчтой тогтоох зорилгоор сум дундын анхан шатын 21 шүүх болгон өөрчлөн байгуулахаар тусгалаа.

Ингэснээр 21 аймаг дахь Сум дундын Анхан шатын 21 шүүх нь тухайн шүүгчийн ачааллыг харгалзан дотроо шүүн таслах ажлын төрлөөр дагнасан танхимын зохион байгуулалттай байх асуудал нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар нээлттэй байгаа.

Одоо байгаа сум дунд, сум дахь сум дундын 8 шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг хэвээр үлдээлээ. Ийнхүү хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүх байгуулах тухай хуулийн дагуу байгуулсан анхан шатын 90 шүүх хуулийн төслөөр 61 шүүх болгож өөрчлөгдөхөөр байна.

2. Давж заалдах шатын шүүхийн тухайд

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн зохион байгуулалтыг хэвээр хадгаллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар Давж заалдах шатын шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болохоор хуульчилсан боловч Үндсэн хууль болон бусад олон улсын гэрээгээр баталгаажсан хүний үндсэн эрхийг хангах, хамгаалах хүрээнд Давж заалдах шатын шүүхийн одоогийн тогтолцоо, байрших газрыг хэвээр хадгалахаар тусгалаа.

Харин 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар одоогийн 21 Аймгийн давж заалдах шатны шүүхүүдээс Орхон, Дархан-Уул аймгуудын Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх тусдаа байгуулагдсан байгааг бусад 19 аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхтэй адил зарчмаар тус 2 аймагт эрүү, Иргэний давж заалдах шатны шүүх болгон нэгтгэж өөрчлөн зохион байгуулахаар санал болгож байна.

Ингэснээр хууль хэрэглээний нэгдмэл байдал сайжирч орон нутаг дахь иргэд шүүхийн шийдвэрийг давж заалдах Үндсэн хуульд заасан үндсэн эрх бодитой хангагдана.

Түүнчлэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар давж заалдах шатын шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн зөвлөгөөн санал гаргаж Улсын Дээд шүүх шийдвэрлэхээр асуудал нээлттэй байгаа. Захиргааны хэргийн давж заалдах шатын шүүхийг хэвээр үлдээлээ.

Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатын шүүхийг нийслэлийн хэмжээнд 1 байгуулахаар санал болгож байна.

Ингэснээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүх байгуулах тухай хуулиар байгуулсан давж заалдах шатын 26 шүүхийг 25-н шүүх болгон өөрчлөн зохион байгуулахаар байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан нийтдээ 340 гаруй тэрбум төгрөгийн зардлын тооцоо гарахаар байгаагаас хүний нөөцийн зардал 47 тэрбум, материаллаг зардал буюу барилга байшинд 297 тэрбум, бусад зардалд 900 сая төгрөг орчим гарахаар байна.

Шүүхийн барилга, байгууламж шинээр барихтай холбоотой төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах боломжтой гэж үзэж холбогдох Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагуулж өргөн барьж боловсрууллаа.

Шүүх байгуулах тухай хуулийг хэрэгжүүлэх боломжит хугацааг Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатын шүүх Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын шүүх, тойргийн шүүх байгуулах заалтын тухайд 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, бусад шүүх байгуулах тухайд 2024 оны 1 дүгээр

сарын 1-ний өдрөөс хэрэгжих боломжтой гэж үзсэн.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 1 дүгээр сарын 4-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөхөөр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн авлигын хэргийг давж заалдах шатын шүүх анхан шатын журмаар, хяналтын шатын шүүх давж заалдах шатын журмаар хянан шийдвэрлэх, өөрчлөх зохицуулалтыг авлигатай тэмцэх бодлогын хүрээнд ердийн горимоор үйлчлэхээр тусгалаа.

Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүх байгуулахтай холбоотой судалгаануудыг хавсаргасан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралд оролцож байгаа хүрэлцэн ирсэн албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Эрдэнэбулган, Г.Эрдэнэбулган. Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн

танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Х.Ариунболд, Нээлттэй нийгэм форумын менежер П.Бадамрагчаа гэсэн хүмүүс оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Дээд шүүх саналаа нэгтгээд Засгийн газар өргөн барьж байна гэж ойлгож байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхлээр энэ бол Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг л Засгийн газар дамжуулж байна гэж ойлгоод байгаа шүү. Энэ дээр 2, 3 асуулт байна. 4-н ч асуулт байна.

Нэгдүгээрт, авлигын тусдаа шүүх байгуулъя гэдэг санал орж ирээгүй юм байна гэж ойлголоо. Ийм санал Засгийн газраас өргөн баригдаагүй юм байна. Энэ олон нийтэд хэвлэл мэдээллээр их ойлгомжтой хэлмээр юм байна. Энгийг Энхбаяр сайд тайлбарлаадхаач. Хаанаас ийм яриа хөөрөө гарчхав.

Хоёрдугаарт авлигын хэргийг анхан шатаар шийдвэрлэхгүй болж байгаа юм байна. Давж заалдах шатын шүүх, анхан шатаар хэлэлцээд хяналтын шатын шүүх давж заалдахаар хэлэлцээд ингээд асуудал дуусдаг болж байгаа юм байна. Энэ Батцэрэн шүүгч ээ шүүхийн тогтолцоонд чинь болж байгаа юм уу. 1 хэргийг шат ахиулаад, анхан шатгүй

болгоод, анхан шатыг нь шууд давахаар хэлэлцдэг болчхож байгаа чинь энэ шүүхийн практикт байдаг зүйл үү. Энэ шүүхийн тогтолцоонд чинь сөрөг нөлөө үзүүлэхгүй юу. Хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт, энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирээд энэ чинь 2000 онд бөөн юм болж байж, бид нар 20 онд бөөн юм болж байж хэргийг нь хэрэгтэнтэй нь хамт, хүнтэй нь хамт шилжүүлдэг болсон байхгүй юу. Одоо Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийнхэн хэрэг шилжүүлнэ хүнээ та нар өөрсдөө олоод ав гээд л хаях юм байна л даа. Ийм өөрчлөлт оруулж ирсэн байна. Энэ бодвол шүүх дээр хорихоос бусад төрлийн ялын гүйцэтгэл нь овоорчлоод хүндрэл учирчхаад байгаа юм байлгүй дээ. Энийг тайлбарлаадхаач.

Дөрөвт, энэ нийслэлд анхан шатаар ч гэсэн, давж заалдахаар ч гэсэн гэр бүл, хүүхдийн шүүх байгуулах санал орж ирж байна. Гэр бүлийн хэрэг гэдгийг ойлгоод байгаа юм. Гэр бүлийн хуулиараа ингээд тэр өмчийн маргаан, бүртгэл юу байдаг юм энийг ойлгоод байгаа юм. Хүүхдийн асуудлаар гэхлээр энэ чинь яг ямар асуудлууд орж ирэх юм бэ. Хүүхэд эрүүгийн гэмт хэрэгт өртөгдчихсөн бол тэр чинь Эрүүгийн хуулиар явах ёстой. Иргэний маргаан гарсан бол тэр чинь Гэр бүлийнхээ хуулиар явчихна. Тэгэхлээр яг энэ хүүхдийн гэдэг яг ямар асуудлууд орж ирэх гэж байгаа юм бэ. Тэр хүүхдэд асран хамгаалагч тогтоох гэж байгаа бол энэ чинь угаасаа л Гэр бүлийн хуулиараа, Иргэний хуулиараа л яваад өгнө шүү дээ.

Харин энэ ачаалал нь хэр байх юм бэ. Одоо та нарт бодвол тооцоо, судалгаа байгаа байх л даа. Нийслэлд энэ зөвхөн гэр бүл, хүүхдийн асуудлаар тэдэн хэрэг өнгөрсөн онд, сүүлийн 10 жилд жилдээ дунджаар төд шийдэгдлээ гээд. Энийг харин би энэ дараа дараагийн тав дахь асуудал болгож асууж байгаа юм шүү. Энийг харин Гэр бүл, хөдөлмөрийн хуулийн, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн

шүүх болгож дагнавал яадаг юм бэ. Нүдэн баримжаагаар юм уу хар ухаанаар бодоход энэ хөдөлмөрийн маргаанууд бол энэ гэр бүл, хүүхдийн маргаанаас дутахгүй илүү гарч байгаа даа. Их цаг авч байгаа байх.

Зургаа дахь асуулт, Энэ захиргааны анхан шатын шүүхүүдийг тойргийн журмаар байгуулах бололцоо байхгүй юу. Аймаг болгон дээр захиргаа, анхан шатаараа л байгаад байх юм. Давах нь ч яах вэ нийслэл дээр ингээд нэг шүүхээр, энэ захиргааны анхан шатын шүүхээр хэргээ шийдвэрлэж байгаа хүмүүс чинь харьцангуй юу гэдэг юм эрх зүйн мэдлэгтэй, харьцангуй төр, захиргааны байгууллагуудтай харьцаад сурчихсан хүмүүс л голцуу орж байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Эрүү, иргэнтэй харьцуулахад.

Тэгэхлээр энийг давахаар хийчихэд бол болохгүй юм байхгүй л санагдаад байх. Давахаар гэнэ тойргоор хийчихэд. Яах вэ Цэцийн дүгнэлт байгаа л даа. Тэгэхдээ энэ чинь захиргааныхад хамаарахгүй.

Д.Цогтбаатар: 6 асуулт байна. Яг асуулт асуултаар нь хариулаад явмаар байна. Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Энхбаяр сайд хэн хариулах вэ. Асуултад хариул. Энхбаяр сайдаас эхэлбэ.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил даргын асуултад хариулъя. Тэгэхээр сүүлийн үед авлигын гэмт хэрэг, авлига албан тушаалын гэмт хэргийн гаралт эндээс учирч байгаа хохирлын хэмжээ, цар хүрээ үлэмж нэмэгдсэн байгаа.

Ер нь авлигын гэмт хэргийн улмаас учирч байгаа хохирол бол хэдэн их наядаар хэмжигдэж байгааг Авлигатай тэмцэх байгууллагаас бас мэдээлэл хийсэн байдаг. Хохирол барагдуулалт нэмэгдэж байгаа, цар хүрээ нэмэгдэж байгаа. Үүний сүүлийн үед гарч байгаа хэргүүд нь улс орон дамнасан дандаа улс төрд нөлөө бүхий хүмүүсийн оролцоотой, гадаад улс орнуудаар данс

нээсэн, мөнгө хөрөнгүүд авсан, байршуулсан зэргээр ердийн гэмт хэргийг илрүүлдэг ийм арга ажиллагаанаас гарвал энэ авлигын гэмт хэрэгтэй тэмцэх боломжгүй болж байгаа юм. Хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ арга ажиллагаануудыг сайжруулах ийм шаардлага болж байна. Энийг хянаж байгаа мөрдөгч, илрүүлж байгаа мөрдөгч нар, хянаж байгаа прокурорууд шийдвэрлэж байгаа шүүгчийн ур чадварууд нь цагаан захтнуудынхаа ухаанаас хэдэн 10, 20 жилээр хоцорсон байгаа. Энэ мөнгө угаадаг схемийг илрүүлэх, энийг нотлох, гэмт хэрэгтнүүд маань ухаантай байгаад байна. Эрх мэдэлтэй, мөнгөтэй, хэвлэлтэй, сүлжээтэй байгаад байдаг. Үүнийг шийдэх гэж байгаа анхан шатын шүүх чинь ердийн тийм танхай шийддэг ийм шүүгч байгаад байгаа юм.

Тийм учраас ер нь ийм хэргээ шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр энэ тогтолцоогоор бол бид энэ авлигачдаа ер нь намнаж дийлэхгүй юм байна гэж Засгийн газар үзэж байгаа юм.

Тийм учраас Шүүх байгуулах тухай хуулийг дагалдуулж өргөн барьсан Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 3-д авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах асуудлаар тодорхой санал, эх үүсвэрээс саналаа Улсын Их Хуралд өргөн барих байх. Ийм үүрэг даалгавар Засгийн газар өөрсдөө авах гэж байгаа юм. Энэ бол улс төрийн Засгийн газрын өөрийнх нь бодлого бөгөөд хүсэл эрмэлзэл байгаа. Энэ хүсэл эрмэлзлийг Улсын Их Хурал дэмжиж, энэ шийдвэрийг, тогтоолыг баталж өгөх юм бол Засгийн газар яаралтай энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхтэй хамтарч ажиллана.

Яагаад гэхээр Шүүхийн тухай хуульд зааснаар шүүх байгуулах хуулийг Засгийн газар дангаараа өргөн санаачилга гаргаж өргөн барих бололцоогүй байгаад байгаа юм.

Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулаад, Улсын дээд шүүхийн санд зөвшилцсөн саналыг Засгийн газар хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн барих ийм зохицуулалттай байгаад байгаа юм гэдгийг хэлье танд.

Д.Цогтбаатар: Дараа нь Батцэрэн шүүгч. Батцэрэн шүүгч 3 руу солигдоод суух уу та. Наана чинь микрофон өгөгдөхгүй байгаа. Харин тийм байнга ийм, анхан.

Б.Батцэрэн: Улсын дээд шүүхийн шүүгч Батцэрэн та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хууль болоод Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүхийн үндсэн тогтолцоог анхан, давж заалдах, хяналтын шатын шүүх гэсэн ийм байдлаар хуульчилсан.

Тэгэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Дээд шүүх давж заалдах болон хяналтын журмаар доод шатын шүүхийн шийдвэрийг хянан үзэж, мөн Шүүхийн тухай хуулийн 25.7.1-д хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг маргааныг анхан шатын журмаар хянан шийдвэрлэх, мөн хуулийн 25.7.2-т Давж заалдах шатын шүүх анхан шатын журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх бүрэн эрхийг тус тус хуульчлан заасан байгаа юм.

Тэгэхлээр хууль тогтоогч Давж заалдах шатын шүүхийг тодорхой төрлийн хэргийг анхан шатын журмаар шийдвэрлэх, Хяналтын шатын шүүхийг давж заалдах журмаар шийдвэрлэх ийм харьяаллыг, шүүхийн харьяаллыг тогтоосон тохиолдолд бол энэ нь Үндсэн хууль болоод Шүүхийн тухай хуультай зөрчилдөхгүй байгаа юм.

Монгол Улсад урьд нь ийм уламжлал бий юу гэвэл 1994 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд онц хүнд ангиллын гэмт хэргийг Давж

заалдах шатын шүүх анхан шатын журмаар шийдвэрлэж ирсэн. Их үнийн дүнтэй буюу 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нэхэмжлэлийг Давж заалдах шатын шүүх иргэний хэргийг анхан шатын журмаар шийдвэрлэж ирсэн ийм уламжлал бол бий.

Одоо Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр бүлэгт зарим төрлийн маргааныг Давж заалдах шатын шүүх анхан шатын журмаар хянан шийдвэрлэх тусгай журмыг хуульчилсан байгаа. Энд хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд үйлчлэх захиргааны хэмжээтэй акттай холбоотой маргаан мөн аймаг хооронд аймаг, нийслэлийн хоорондын маргаан Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргаан, хуульч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, эрх олгохоос татгалзсан тухай шийдвэр, Өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэртэй холбоотой маргаанууд, Засгийн газар Монголбанкнаас гаргасан шийдвэртэй холбоотой маргаан, хуулиар тусгайлан заасан бусад маргаан эдгээрийг Захиргааны хэргийн Давж заалдах шатын шүүх анхан шатын журмаар шийдвэрлэх ийм тусгай журам хуульчлагдсан ингээд хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байрилыг тогтоох асуудлыг Улсын Дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх байгуулах хуультай холбогдуулж 2 удаа Улсын Дээд шүүхэд санал ирүүлсэн. Тухай бүр нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж саналаа өгсөн. Одоо Улсын Их Хуралд өргөн барьсан энэ төслийн хувилбарыг яг

энэ байдлаар нь Улсын дээд шүүх хэлэлцээгүй. Мөн энэ Улсын Их Хуралд өргөн барьсан Шүүх байгуулах тухай хууль түүнийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах тухай ийм төслийн заалт бол байгаагүй.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хүрээнд авлига, албан тушаалын хэргийг Давж заалдах шатын шүүх анхан шатын журмаар шийдвэрлэх, хяналтын шатын .../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофоныг өгье.

Б.Батцэрэн: Хяналтын шатын шүүх авлига, албан тушаалын хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх хуулийн төсөл санал авахаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн. Энэ саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцээд тусгайлан санал бол гаргаагүй.

Ачааллын талаар Мөнх-Оргил гишүүн асуусан. Энд би бас тодорхой хариулъя гэж бодож байна. Энхбаяр гишүүн бас түрүүн хэлсэн авлига, албан тушаалын хэрэг сүүлийн 3 жилийн байдлаар динамик өсөлттэй байгаа. 2022 онд шийдвэрлэсэн улсын хэмжээнд анхан шатын шүүх 417 хүнд холбогдох.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье, гүйцээгээд хариулъя

Б.Батцэрэн: 2022 онд Анхан шатын шүүхүүд 417 хүнд холбогдох 182 авлига, албан тушаалын хэргийг хянан шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байгаа. Давж заалдах шатын шүүхэд 2022 онд 269 онд холбогдох 100 хэргийг хянан шийдвэрлэсэн. Энэ нь 2021 онд шийдвэрлэсэн хэргээс 3.5 дахин өссөн

үзүүлэлттэй байгаа юм. Хэрэв авлига, албан тушаалын хэргийг давж заалдах шатын журмаар шийдвэрлэх энэ шүүхийн харьяаллыг Хяналтын шатын шүүхэд шилжүүлэх тохиолдолд энэ 100 орчим хэрэг тодорхой ажлын ачаалалд нөлөөлнө.

Гэхдээ авлига, албан тушаалын хэрэгт бас онцлог бий. Энэ нь ихэвчлэн хамтран оролцооны өөр өөр хэлбэрээр бүлэглэж үйлдэгддэг. Хахууль авсан хэрэгт өгсөн, авсан хэн аль нь шийтгүүлдэг. Тэгэхлээр энэ хэргийн тооноос гадна бас шүүгдэгчийн тоо ачаалалд тодорхой нөлөөлдөг. Эндээс харахад Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслахын ажлын ачаалал бол 50 гаруй хувиар нэмэгдэх ийм төлөвтэй байгаа юм.

Гэхдээ саяын дурдсан тоо баримт бол авлигын нөхцөл байдлыг бүрэн харуулахгүй байгаа. Өөрөөр хэлбэл албан тушаалаа урваж хөрөнгө зависан хэргүүд бол шүүхийн практикт өмчийн эсрэг хэрэг буюу 17.3.2.1, 17.4.2.1-ээр шийдвэрлэгдэж байгаа. Эдгээр хэргүүд нь Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах харьяаллаас гадуур гэмт хэрэг үйлдсэн, газрын мөрдөх байгууллагаар шалгаж байгаа. Үүнтэй холбоотой Эрүүгийн хуульд энэ авлигын гэмт хэргийн үндсэн шинжийг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод бүрэн нийцүүлэх, мөн үүнтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах ийм шаардлагууд байгаа гэж бас харж байна. Ачааллын хувьд ийм байна.

Д.Цогтбаатар: Х.Ариунболд хурандаа Шийдвэр гүйцэтгэл. 2 дугаар микрофон уу. 3 дугаар микрофон өгчихье. 3 дээрээ ер нь солиод солиод суучих.

Х.Ариунболд: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдийн амрыг эрье. Хурандаа Ариунболд илтгэж байна. Өнөөдөр Шүүх байгуулах тухай хуультай уялдуулаад энэ манай хуульд нэмэлт, өөрчлөлт орохоор бас тусгагдсан байгаа талаар бас та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлаар 2017 онд хэлэлцсэн хуулиараа бол манай хуульд шүүхийн шийдвэрийг ялтан этгээд албадлагын арга хэмжээ авагдсан этгээдтэй авахаар зохицуулалт орсон. 20 оны 1 сарын 10-наас хэрэгжиж байна.

Манай хуучин парламентад байсан гишүүд маань бас тухайн үеийг санаж байгаа байх. 20 онд бол бид нар 17 онд 3155 хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ авагдсан этгээд дээр хяналт тавьж ажиллаж байсан. Тухайн үедээ тухайн үеийн парламент Засгийн газарт танилцуулаад өөрчлөлт орсон тохиолдолд хориод мянган ялтан албадлагын арга хэмжээ авагдсан этгээдтэй болох юм байна. Энэ дээр бид нар зайлшгүй ялтан этгээдийг шийдвэр гүйцэтгэх хуудас, шийдвэрийн хамт хүлээж авахаар зохицуулалт хийж өгөөч гэж Байнгын хороо болон Их Хурлаараа шийдүүлсэн. 153.1 нь байсан. 1 нь байгаагүй, 185.1 нь байсан. Ингээд шийдсэнээрээ өнөөдрийн байдлаар бол хорихоос өөр төрлийн албадлагын арга хэмжээ авагдсан этгээд ялтныг бид нар өнөөдрийн байдлаар алдаж асгаагүй ажиллаж байна.

23 оны өнөөдрийн байдлаар бол бид нар 23962 буюу 24000 албан хаагчид ялтан албадлагын арга хэмжээ авагдсан этгээд дээр хяналт тавьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 104 албан хаагч л 24000 албадлагын арга хэмжээ авагдсан. Ялтан этгээд дээр хяналт тавиад явж байгаа дээрээ бид нар ингээд 1 хүн дээр 427-450 гүйцэтгэх хуудас байна.

Хэрвээ энэ хуулийн бас төсөл дээр явж байгаа асуудлаар энэ төсөл хэрэгжээд явбал бид нар бол эрэн сурвалжлах ажил руугаа анхаараад, шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт Шүүх ерөнхий зөвлөлийн мэдээ, Улсын дээд шүүхийн мэдээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээ бол ерөөсөө доошоо унана гэсэн мэдээллийг албан ёсоор өгч байна.

Өнөөдрийн байдлаар хорихоос өөр төрлийн ял, албадлага арга хэмжээ авагдсан этгээдийг алдаж асгаагүй 1 ч хүн оргоогүй гэдгийг илтгэж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-т шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэх журмыг Ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нарын 21 онд баталсан журам дээр яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дурдсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохиогч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах журмын 4.20-д хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг шүүхийн шийдвэрийн хамт шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгөхөөр шүүхээс дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар албадан ирүүлэх арга хэмжээ авч болно гэж заасан байгаа.

Энэ чиглэлийн ажил бол өнөөдөр цагдаагийн байгууллага, шүүхийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын хооронд уялдаатай. Энэ дээр ямар нэгэн асуудалгүй явж байгаа гэж манай байгууллага энийг ойлгож байгаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д гэмт хэрэг зөрчил үйлдсэн нь цээрлэгдэж байгаа хүн,

эсвэл оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан ял оногдуулахыг тэнсэж албадлагын арга хэмжээ авагдсан хүн эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэр, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгаврын дагуу эсвэл өөрөө санаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье. Товчхон та яг сая асуусан асуултад нь хариулаад л явчих.

Х.Ариунболд: Манайхаас санал авсан. Саналыг бол манайх ийм ийм боломжгүй гэдгээ саналаа өгсөн байгаа.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд яг энэ асуудал дээр Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Засгийн газраас өргөн барьж байгаа хуулиуд бол байгууллагын бүх санал тусаж өргөн баригддаггүйг та бүхэн ойлгож байгаа. Ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой асуудлууд тал талын саналуудыг авч байж өргөн баригддаг. Энд бол шүүх байгууллагын зүгээс гаргасан саналууд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бас гаргаж байгаа саналууд мөргөлдөж байгаа асуудлууд бол бий.

Тийм учраас энийг бол хууль тогтоогч өөрөө бас ажлын хэсгийн хүрээнд тал талуудын байр сууриудыг сонсож, шийдлээ гаргах боломжтой гэж үзэж байгаа.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон Ундрах. 1 дүгээр микрофон байна.

Б.Ундрах: Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн ерөнхий зөвлөл өөрийн чиг үүргийн хүрээнд Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлдэг. Монгол Улсын хэмжээнд 41 Тамгын газар ажиллаж байгаа. Энэ бүх Тамгын газруудад 1 асуудал үүссэн. Энэ бол 1 жилийн асуудал биш, өмнө нь огт

ярьж байгаагүй зүйл биш. Ярьж байгаа зүйл байсан учраас нэгдүгээрт, хоёрдугаарт хуулийг бүрэн зохицуулахгүй бол болохгүй байгаа учраас бид нар энэ асуудлыг оруулж ирсэн.

Яагаад шүүх байгуулах хуультай холбоотой оруулж ирээд байгаа юм бэ гэхээр шүүх байгуулах хуультай холбоотой Тамгын газрын үйл ажиллагаа өөрчлөгдөнө. Эрүү, Иргэний шүүх бий болно. Одоо бол Эрүү дангаараа байгаа.

Хоёрдугаарт, бид нар шүүхийн үйл ажиллагааг цэгцлэх ёстой. Дараа дараагийнхаа өөрийнхөө шүүхийн байгуулах тухай хуультай холбогдуулаад. Тэгэхээр өнөөдрийн байдлаар буюу 2023 оны 9 сарын байдлаар би мэдээллийг өгье. Өнөөдрийн байдлаар 141 сая 7689 төгрөгийн торгох ялтай 174 хүн, нийтэд тустай 58709 цагийн ажил хийх 151 хүн, тэнссэн 55, зорчих эрхийг хязгаарласан 447 хүн, нийт 427 хүн шүүхийн шийдвэр гарснаас хойш шүүхэд хүрэлцэж ирээгүй. Энэ хүмүүсийн бичиг баримтыг бид нар шийдвэр гүйцэтгэх албанд хүргэж өгч чадахгүй байгаа. Тэгэхээр үндсэндээ ийм тооны хүн ял завишж байна гэсэн үг.

Юунаас болоод энэ асуудал үүсчих вэ гэхээр ерөөсөө цэвэр хууль хэрэглээний асуудал л байгаа. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 5 хоногийн дотор хүргэж өгнө гэсэн заалт байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хүнтэй нь авна л гэсэн заалт бий. Саяын яриад байгаа 153. Тэгэхээр хүнтэй авна нэгэнт тогтоол хүчин төгөлдөр болно гэдэг асуудал. Асуудал юундаа байна вэ гэхээр таслан шийдвэрлэх тогтоол гарсны дараа буюу хэрэг шийдэж дууссанаас хойш шүүх ямар нэгэн арга хэмжээ авах хуулийн заалт байхгүй. Өөрөөр хэлэх юм бол ял өглөө. Тэрнээс хойш шүүх ямар нэгэн эрхийн акт гаргах бүрэн эрх хуулиараа байхгүй.

Тэгэхээр сая яриад байгаа тэр захирамж гаргаад албадан авчрах, эрэн

сурвалжлах ийм бүрэн эрх хуульд байхгүй.

Дараагийн асуудал бол сая хамтарсан тушаал ярьсан. Тэр хамтарсан тушаалд тийм заалт бий. Гэхдээ шүүх бол хуулийг барих ёстой. Хүний эрхийг хязгаарлахдаа хууль барина. Ямар нэгэн хамтарсан тушаал барихгүй. Манай шүүгч нар хууль бус үйл ажиллагаа буюу үндэслэлгүй тогтоол гарах юм бол Сахилгын хороонд очдог. Тийм учраас манай шүүгч нар энэ тогтоолыг барихгүй байгаа. Тэгэхээр өнөөдөр эрэн сурвалжлах асуудал энд зогсчихсон. Ялтныг эрэн сурвалжлах.

Тийм учраас бид нар хуулийнх нь зохицуулалтыг нь нэг мөр шийдье. Ямар гарц байна вэ гэхээрээ хүнтэй нь авчрах ийм боломж бол алга. Таслан шийдвэрлэх тогтоол гарснаас хойш шүүх зөвлөлдөх тасалгаанд гаргасан шийдвэрээ хуульд зааснаар 5-14 хоногийн дотор бичих ёстой. Тэгээд бичээд, албажуулаад хүнээ дуудахаар ирдэггүй. Тэгээд л авчирч чадахгүй. Авчирч чадахгүй учраас шийдвэр гүйцэтгэл хүлээж авахгүй ийм л асуудал байгаа. Энийг бол шийдвэр гүйцэтгэлийн байгууллага, Хууль зүйн яам, Монгол Улсын Дээд шүүхтэй хамтарч ярьсан.

Тэгээд аливаа ажил хуулийн хүрээнд явагдах ёстой. Бид нар хүний эрхийг хязгаарлах асуудлыг ширээний ард суугаад албан бусаар ярьж болохгүй. Тийм учраас хуульд заасан журмынх нь дагуу хийе гээд бид нар энэ асуудлыг оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ асуудал яаж шийдэгдэх вэ гэхээр хүнтэй нь авчирч өгөх чиг үүргийг хэн хүлээдэг юм бэ гээд. Тэгэхээр цагдаагийн байгууллага шүүхийн шийдвэргүйгээр асуудал шийдэхгүй. Заавал шүүхийн шийдвэр гарч байж л цагдаагийн байгууллага эрэн сурвалжилна. Тэгвэл шүүх энийг гаргаж чадахгүй байгаа. Хуульд тийм заалт байхгүй. Шүүх өөрөө гаргаад эрэн сурвалжлах бас чиг үүрэг байхгүй.

Тэгэхээр өнөөдөр хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд шийдвэр гүйцэтгэлийн байгууллага энийг хийнэ. Тэр Эрүүгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 3 асуудал байгаа. Эрүү, Иргэн, Захиргааны шийдвэрийг биелүүлэх гээд. Эрүү, Иргэн, Захиргааны шийдвэр. Иргэн, Захиргааны шийдвэр дээр буцаах зохицуулалт байгаа. Хэрвээ хуульд нийцэхгүй, шийдвэр болон гүйцэтгэх бичиг баримт байвал буцаана гээд. Эрүү дээр энэ байдаггүй. Өөрөөр хэлэх юм бол шууд хүлээж аваад энэ биелүүлэх ёстой. Энэ бол ял биелүүлж байгаа асуудал байгаа.

Тийм болохоор энийг бид нар хуулийн хүрээнд нь хийе гэж үзээд Шүүх байгуулах тухай хуультай холбогдуулаад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг нь оруулсан байгаа.

Д.Цогтбаатар: Онончимэг дарга Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бас асуулт асуусан юм шүү дээ. Энэ сая Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай холбогдох асуултад харцуулж дууслаа гэж ойлгож байна. Танайхаас асуусан асуултад 2 дугаар микрофон.

А.Насандэлгэр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Насандэлгэр байна. Гишүүний асуулт Гэр бүл, хүүхдийн шүүхийг байгуулж байгаа талаар тэр дотроо энэ шүүхэд өсвөр насны хүүхдийн хэрэг яаж харьяалагдаж байгаа мөн ачаалал ямар байгаа талаар асуулаа гэж ингээж ойлгосон.

Тэгэхээр Шүүх байгуулах тухай хуулийг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй зөвшилцөж 22 оны 11 сард, 2 дахь удаагаа 23 оны 6 сард Засгийн газарт өргөн мэдүүлсэн. 23 оны 6 сард Засгийн газарт өргөн мэдүүлсний дараа Засгийн газраас Гэр бүл, хүүхдийн шүүхийг байгуулах санал ирсэн юм. Энэ дагуу бид нар бас өмнөх явуулсан юунаасаа тусад нь Улсын дээд шүүхтэй зөвшилцөөд, тэгээд Улсын дээд шүүхтэй

зөвшилцсөн саналаа Засгийн газарт өргөн мэдүүлсэн. Ингээд нэгтгэгдэхэд орж ирж байгаа гэж ингээж ойлгож байгаа.

Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулахтай холбоотой статистик судалгааг, тоон үзүүлэлтийг бол хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөл дээр байдаг энэ дата, мэдээлэлд үндэслээд судалгаанууд гарсан. Энэ шүүх дээр ямар хэрэг харьяалуулах гэж байгаа вэ гэхээр Гэр бүлийн хуулиар хянан шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн эрүүгийн хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдүүдийн холбогдсон буюу хохирсон хэргүүдийг харьяалуулж шийдвэрлүүлье гэсэн энэ агуулгаар энэ хуулийг боловсруулсан.

Гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн өсвөр насанд хүрээгүй хүүхдүүдийн эрх бол маш ихээр зөрчигдөж байгаа. Жилээс жилд өсөж байгаа. Энэ насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хэргийг тусгай орчинд мэргэшсэн шүүгч энэ хүүхдийн сэтгэл зүйд онцлогт тохирсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалах ийм зайлшгүй онцлог шаардлага байна гэж үзэж энэ шүүхийг байгуулж байгаа гэсэн ийм томъёоллоор Гэр бүл, хүүхдийн шүүхийг нийслэлд анхан шатын журмаар, давж заалдах шатын журмаар улсын хэмжээнд байгуулахаар өргөн мэдүүлэгдэж байгаа.

Ачааллын хувьд бол иргэний хэрэг дээр шийдвэрлэгдэж байгаа гэр бүлийн маргааныг 10-12 хувийг нийслэлд шийдвэрлэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн хэрэг бол тооны хувьд бол цөөхөн боловч зүгээр нийт хэрэгт эзэлж байгаа хувьд бага боловч тооны хувьд бас нэлээн байдаг. Тэгэхээр бид нар яг өөр дээр байгаа статистик тоогоо гаргаад 22 оны тоон үзүүлэлтээр гаргасан, мөн сүүлийн 5 жилээр гаргасан байгаа та бүхэнд яг гэр бүлийн

хүчирхийлэл үйлдсэнтэй холбоотой 22 оны тоон үзүүлэлтийг та бүхэнд хэлье.

Тэгэхээр гэр хуулийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 22 онд улсын хэмжээнд 117 буюу 1 хувийг л эзэлж байгаа юм. Нийслэлийн хэмжээнд бол 0.4 хувь эзэлж байна. 32 гэмт хэрэг байна гэж ингэж гарч байгаа. Энэ дотроо бол яг хохирсон хүүхдийн тоо 441 болчихоод байгаа юм. Холбогдсон хүүхдийн тоо бол мөн 0.4 хувийг л эзэлдэг ийм нийслэлийн хэмжээнд ийм л тоон үзүүлэлт байгаа.

Гэхдээ эзэлж байгаа хувиар биш тоон үзүүлэлтээр аваад үзэх юм бол энэ нь үндсэндээ сүүлийн 20 оноос хойших үзүүлэлтийг аваад үзэх юм бол 35 хувиар өсжээ гэсэн ийм үзүүлэлт, статистик манай дээр байна.

Д.Цогтбаатар: Тэгье, Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Засгийн газраас авлигатай авлигын шүүх гэж тусад нь байгуулъя гэдэг санал бол орж ирээгүй юм байна. Ийм асуудлыг судалъя гэдэг санал орж ирж байгаа юм байна. Энийг хэдүүлээ тал талаас нь ойлгочихъё. Тэгээд энэ дээр зүгээр санаа зовоосон, санаа зовох ч юу байх вэ дээ анхаарал хандуулах 2 юм байна шүү.

Нэгдүгээрт, энэ хуулиараа Шүүхийн ерөнхий зөвлөл Дээд шүүхтэй зөвшилцөж оруулж ирэх ёстой байгаа байхгүй юу. Тэгээд хамгийн сүүлчийн хувилбараа Дээд шүүхтэй зөвшилцөөгүй байна шүү. Энэ бол процессын алдаа гэж хэлэхээс өөр аргагүй юм байна шүү.

Хоёрдугаарт, Засгийн газраас авлигын шүүх байгуулах санал 2024 онд судлаад оруулаад ирчихсэн тохиолдолд авлигын эсрэг дагнасан шүүх байгуулчихлаа гэж бодоход энэ Эрүүгийн процессын хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт чинь яаж үйлчлэх юм бэ.../минут дуусав./

Ц.Сэргэлэн: Мөнх-Оргил гишүүний микрофоныг ахиж өгье. Тодруулгаа гүйцээе.

Ц.Мөнх-Оргил: Гуравдугаарт, миний тэр хүүхдийн дагнасан шүүх гэж асуугаад байгаа чинь ийм байхгүй юу. Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн жишээ нь Жюниор корт /Junior Court/ гэж байгаа байхгүй юу хүүхдийн шүүх гээд. Тэгэхдээ зөвхөн эрүүгийн хэрэг, зөвхөн гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүдэг эрүүгийн дагнасан шүүх байгаа байхгүй юу. Тийм бол байж болно.

Тэрнээс биш хүүхэдтэй холбогдсон бүх юмнуудыг аваачаад нийслэл дээр ганцхан шүүх дээр шийдвэрлэнэ, хүүхдийн эрх зөрчигдсөн, хамгаалах бүх асуудлууд тийшээ явна гэх юм бол наад чинь хэрэглэгчдэдээ, тэр хүүхдүүддээ, асран хамгаалагч, ар гэрийнхэнд нь энэ чинь аягүй хүндрэл учрах нь байна шүү дээ. Анхан шатдаа тэр асуудлуудыг шийдээд явж болж байгаа байхгүй юу. Бидний хийх гээд байгаа юм чинь бол хүүхдийн эрхийг хүүхдийг гэмт хэрэгт холбогдоход нь насанд хүрсэн хүмүүстэй адилхан 1 шүүхээр, 1 дэгээр, 1 процессоор явуулдаггүй болгоё, арай өөр шүүх байгуулъя гэж л тэр санаа шүү дээ. Тэр рүүгээ оруулахгүй байсан юм уу.../минут дуусав./

Ц.Сэргэлэн: Хаанаас хариулах вэ. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулаад Улсын Дээд Шүүхтэй зөвшилцсөн байсан санал дээр Давж заалдах шатын шүүхийг тойргийн журмаар байгуулах асуудал орсон байсан. Энэ асуудлыг Засгийн газар хэлэлцээд юу гэж үзсэн гэхээр энэ бол парламентын босго давахгүй юм байна нэгдүгээрт. Тэр тусмаа сонгуулийн өмнө, тэр тусмаа манай парламентын 3-ны 2 нь орон нутгаас сонгогдсон төлөөлөлтэй үед.

Хоёрдугаарт, сая шүүхийн хараат бус байдлын асуудлаар ажилласан НҮБ-ын шинжээч тайландаа шүүхийг байгуулахдаа энэ иргэдийг бас чирэгдүүлэхгүй байх. Ялангуяа хөдөө орон нутгийн алслагдсан орон нутагт амьдарч байгаа иргэдийг давж заалдах шатын журмаар хэргээ шийдвэрлэхэд.../минут дуусав./

Ц.Сэргэлэн: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэмж хариулъя. 3 дугаар микрофоныг өгье.

Н.Отгончимэг: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Отгончимэг. Мөнх-Оргил гишүүний 6 дахь асуулт хариулагдаагүй үлдчихлээ. Өмнө нь асуусан. Захиргааны хэргийн Анхан шатны шүүхтэй холбоотой асуулт байсан. Энэ шүүхийн ачааллаас хамааран тойроглох боломж байсан уу гэдэг ийм асуултад хариулъя.

Үндсэн хуульд 19 онд өөрчлөлт ороод шүүхийг тойргийн зарчмаар байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Шүүхийн хуульд бас энэнтэй холбогдуулж тойргийн зарчмаар байгуулбал ямар зохицуулалт баримтлах ёстой вэ гэдэг заалт орсон. Түүнээс гадна бас нэлээн чухал бас эрх зүйн баримт бичиг гэвэл 2020 оны Улсын Их Хурлын 3 дугаар тогтоол байж байгаа. Энэ 3 дугаар тогтоолын 3.3.1-д бол юу гэж заасан бэ гэхлээр шүүх байгуулах хуулийн төслийг боловсруулахдаа дараах хэд хэдэн зарчмыг барьж боловсруулж орж ирнэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье, гүйцээж хариулъя.

Н.Отгончимэг: Энэ Их Хурлын 2020 оны 3 дугаар тогтоолд үндсэндээ иргэн талаасаа шүүхэд хандах иргэдийн эрхийг баталгаатай эдлүүлсэн байх ёстой шүүх байгуулах хууль, түүнээс гадна шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан байх ёстой гээд иргэн талаасаа ийм үндсэн 2 зарчмыг баримтална гэж заасан байгаа.

Шүүх талаасаа бол шүүгчийн мэргэших байдлыг харгалзана шүү. Түүнээс гадна ачааллыг нь харгалзаж тойргийн зарчмаар байгуулна шүү гэдэг ийм зарчим байгаа Шүүхийн ерөнхий зөвлөл Дээд шүүхтэй санал зөвшилцөхдөө яг үндсэн энэ 4 зарчмыг баримталсан. Ингэхдээ бол Давж заалдах шатын шүүхийг бол тойроглох боломжтой юм. Яагаад гэвэл энэ 4 зарчмыг бол нэгэн зэрэг бүрэн хангаж байгаа учир гээд. Анхан шатын шүүх дээр бол энэ тойроглох зарчмыг баримтлаад Захиргааны хэргийн Анхан шатын шүүхийг тойроглоод ороод ирвэл шүүх иргэдээс холдох юм байна гэж дүгнэсэн. Анхан шатанд бол иргэд бол нэхэмжлэлээ шүүхэд гаргаж, шүүхтэй харилцах анхдагч ийм суурь тогтолцоо байж байгаа. Энийг бол тойроглох боломжгүй юм байна. Давахаа бол харин ачааллыг нь харгалзаж байгаад тойроглоё гэдэг байдлаар бол санал хүргүүлсэн байгаа. Дээд шүүх бол үүнийг маш зөвшилцөж дэмжсэн байдаг.

Яагаад захиргааны шүүхийг тойроглож болохгүй байгаа юм бэ гэхлээр Захиргааны шүүх бол Эрүү болон Иргэний хэргийн шүүхээс нэг том зарчмаараа ялгаатай байдаг. Нотлох үүрэг бол Захиргааны шүүх дээр байдаг. Энэ бол харилцан тэнцвэргүй харилцаанд оршдогтой ч бас холбоотой. Тэгэхээр захиргааны хэрэг үүсгээд нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд тухайн аймгийн шүүх нь тухайн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн албан тушаалтан, төрийн захиргааны албан тушаалтантай холбогдох маргааныг шийддэг. Үүнтэй холбогдуулаад бол иргэн нотлох баримт цуглуулах асуудал хүндрэлтэй тулгардаг.

Тийм учир захиргааны шүүхэд бол нотлох үүрэг байдаг учир яг энэ засаг захиргааны нэгж бүр дээр нь захиргааны шүүхийг цаашид хэвээр хадгалаад явах нь бол яг энэ зарчимдаа нийцэх юм байна гэж үзсэн байгаа.

Д.Цогтбаатар: *Хариулт хангалттай юу. 2 дугаар микрофон өгье. 1 дүгээр микрофон өгье. Онончимэг дарга 1 дүгээр микрофон шүү.*

Р.Онончимэг: *Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг байна. Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Яг хөдөлмөрийн маргаан гэдэг дээр тухайлж бид хэд шүүх байгууллагатай холбоотой шалгуур үзүүлэлтээр судалгаа хийгээгүй учраас хариулах боломжгүй байна. Магадгүй хөдөлмөрийн дагнасан шүүх байх шаардлагатай гэвэл бид хэд бас шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгаа хийгээд яаж ачаалал нь орж ирэх байна вэ гэдэг дээр хариулт өгөх бүрэн боломжтой.*

Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн асуудлыг бид бас нэлээдгүй судалсан. Хохирогч болон холбогдогч гэдэг агуулгаар таны яг хэлдэг зөв, яг тухайн хэрэгт холбогдсон хүмүүсийгээ хүүхэд гэдэг агуулгаар бас гадаад орнууд бас харьяаллаа тогтоож явдаг юм байна лээ. Зүгээр бид хэд нийслэлийн хэмжээнд гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхээ ачааллыг нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: *1 дүгээр микрофон, та микрофондоо хариулаарай.*

Р.Онончимэг: *23-30 орчим хувийг харьяалах юм байна гэж тооцоод хүүхэд холбогдсон болон хохирсон бүх маргаануудаа харьяалуулаад оруулчихсан явж байгаа юм. Тэгэхээр энд бас ажлын хэсэг дээр ярилцаад аль хэсгүүд нь байх боломжтой вэ гэж ярилцах бас бүрэн боломжтой байгаа.*

Д.Цогтбаатар: *Хариулт хангалттай юу. Ганбат гишүүний микрофоныг өгье. Энэ Ганбат гишүүний микрофоныг. Энэ байна шүү дээ. Та дахиад гарч байгаад бүртгүүлчих. Ганбат гишүүний микрофоныг өгье.*

Д.Ганбат: *Өнөөдөр манай Байнгын хороогоор шүүхийн талын асуудал орж ирж байна. Гэр бүл, хүүхдийн хэргийн*

анхан шатны тойргийн шүүх гэж ярьж байх шиг байна. Бас хөдөлмөрийн шүүх энэ тэр гээд ярьж байна л даа. Сүүлийн 8 жил байна уу энэ шүүхийн талаар хэр олон хууль орж ирж өөрчлөгдөж явж байна вэ. Шүүхтэй холбоотой энийг би бас тодруулмаар байх юм.

Нөгөө талаар 12-16 онд шүүхийн нэлээн олон хуулиудыг бид нар багцаар нь өөрчилсөн. Шинэчилсэн найруулгын түвшинд энэний дараа шүүх нэлээн сайн ажиглаж эхэлсэн гэж ойлгож байгаа. Тэрний нэг илэрхийлэл нь энэ хараат бус байгууллагын дүгнэлтээр дэлхийн ч хэмжээний авлига, албан тушаалын хэргээр бид нар далан хэдэд орж ирж байсан түүхтэй байна. Хараат бусаар бас нэлээн сайн үзүүлэлтүүдийг гаргаж байсан. Одоо яг ямар байдалтай байна вэ. Сүүлийн үеийн хараат бус гаднын байгууллагын дүгнэлт та нар тэр саяхан бас НҮБ-ынхан ч ирсэн юм шиг байна. Энэ хүний эрх гэдэг асуудал гол асуудал л даа. Хүний эрхийг хязгаарлах эрхэд нь ганцхан шүүх дээр байдаг гэж ойлгож байгаа.

Тодорхой хэмжээний богино хугацаанд тэр прокурорын зөвшөөрөлтэй цагдаа 48, 72 цаг байгаа байх. Үүнээс дээш хэмжээнд шүүх дээр шийдэх ёстой. Энэ тал дээр маш тааруу үзүүлэлттэй байна гэж би ойлгосон. Шүүх дээр тэр нь очдоггүй юм байна, шүүх шийдвэр гаргадаггүй юм байна гээд. Яг өнөөдөр сая гишүүн асууж байх шиг байна. Яг авлигатай тэмцэх авлигын талаарх дагнасан шүүх байгуулах гээд байгаа юм уу, үгүй юм уу. Тэрэнд хэн ч хариулт өгөхгүй байна л даа. Тэр Эрүүгийн дагалдах хуулиудаараа тийм юм орж ирж байгаа юм уу, эсвэл байхгүй байгаа юм уу тэрийг асууя.

Ер нь энэ шүүхтэй холбоотой асуудлаар гэмт хэрэгтэй тэмцэх асуудал мэдээж хэрэг Засгийн газрын асуудал. Засгийн газарт бүх байгууллагууд нь байгаа. Авлигатай тэмцэх газар нь ч байгаа, цагдаа нь ч байгаа, шүүхийн шийдвэр нь ч байгаа. Шүүх бол бас өөрөө

шүүх хараат бус ажиллах ёстой. Тэр 12-16 онд үнэхээр шүүх бол өрөвдмөөр байдалд байсан. Шүүгч нар зайлуул хэдэн ноороосон авгай нар л суудаг. Дээр нь цагдаа, прокурор, шүүхийн шийдвэрийнхэн гараад суучихсан бараг командалж байгаа юм шиг л харьцдаг байсан. Энэ бол сүүлийн үед өөр болсон.

Гэтэл одоо буцаад байдал руугаа орох нь. Шүүхэд хэн дуртай нь нөлөөлж байдаг. Би Анхан шатны шүүхийн шүүгч нарыг маш сайн ажиллаж байгаа гэж ойлгож. Энэ бүрэлдэхүүн 500-гаад хүнтэй бүрэлдэхүүн байгаа. Нэлээн сайн ажилладаг болчихсон. Хамгийн нөлөөлөгдөж байгаа хэсэг бол Давах, Хяналтын шүүх 2 л байгаа гэж ойлгож байна. Энэ ч үзүүлэлтүүд олон улсын байгууллагын дүгнэлтээр гарч байна. Та бүхэн маань юу гэж бодож байна. Энэ хуулиудыг хуучин Ерөнхийлөгчийн зүгээс өргөн барьдаг байсан. Яагаад гэвэл бүх ард түмнээс сонгогдсон, аль нэг намд харьяалагдахгүй ийм хүмүүс байдаг. Энэ удаагийн Ерөнхийлөгч тэр шаардлагыг энэ үндсэн хугацаанд бүрэн биелүүлж ажиллаж байгаа гэж ойлгож байна. Тэр байтугай Авлигатай тэмцэх газрын даргыг томилох эрхээсээ хүртэл больж, Засгийн газар шилжүүлж байсан ийм зөв жишиг тогтоож байсан. Өнөөдөр хэд хэдэн зүй.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах вэ та минутаа нэмээд авчих уу. Ганбат гишүүний микрофоныг өгье. 1 минут нэмж өгье.

Д.Ганбат: Хуучин тэр маршалын албыг бид нар байгуулчихсан байсан. Шүүхээ бэхжүүлэх талаар бид нар яагаад ярихгүй байна. Шүүхийг хараат бус ажиллах талаар боломжийг нь яагаад өгөхгүй байна. Тэр Мөнх-Эрдэнийн шүүхийн Давж заалдах шатны шүүх дээр би очсон. Хотын хамгийн гайгүй гэж байгаа нь тэр. Үгүй тэр чинь ямар ч шаардлага хангахгүй л өрөөнүүд байна лээ шүү дээ. Яагаад ийм зүйлээ ярьдаггүй юм бэ. Шүүхийг хамгаалах, шүүгч нарыг хамгаалах, гэрчийг хамгаалах энэ бүх зүйлүүд чинь хаана

явж байгаа юм бэ. Энэ ажлуудаа яагаад хийж болохгүй байгаа юм бэ. Тэгээд энэ авлига, албан тушаал энэ хэрэгтээ бол сүүлийн үед тэмцээд их амжилт олсонгүй. Энэ бүх зүйлийг хамгийн сүүлд шүүх буруутан нь болж үүрэхээр тэр зам руугаа явж байна уу, ямар байна гэсэн ийм хэдэн асуудлууд байна л даа. Шүүх юу гэж бодож байгаа юм. Засгийн газар юу гэж бодож байгаа юм энэ асуудлыг. Олон дахин ийм юмаар.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ. Ажлын хэсгээс 2 дугаар микрофон өгье.

А.Насандэлгэр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Насандэлгэр байна. Ганбат гишүүний асуултад хариулъя. Намайг дутуу хариулбал манай гишүүд бас нэмээд хариулаад өгөөрэй.

Сүүлийн 8 жилд шүүхтэй холбоотой хуулиуд хэрхэн өөрчлөгдсөн талаар асуулаа. Ер нь бол Шүүхийн тухай хууль 1993 оны Үндсэн хуулиас хойш 4 удаа шинэчлэн найруулагдаж өөрчлөгдсөн байгаа. Энэ хугацаанд Шүүх байгуулах тухай хууль 5 удаа батлагдаж, хамгийн сүүлд 2021 оны 3 сарын 1-ний шинэ хууль маань одоо ингээд үйлчлээд явж байна.

Шүүх дээр хэрэглэгддэг хуулиудын хувьд бол байнгын процессоороо өөрчлөлт ороод явж байгаа. Хамгийн сүүлийн, хамгийн түгээмэл хэрэглэгддэг процессын хуулиуд дээр өөрчлөлт ороод явж байна. Одоо ч гэсэн Засгийн газар дээр процессын хуулиудтай холбоотой өөрчлөлтүүд яригдаад явж байгаа. Хуулийн процесс бол яг энэ өөрчлөлтийнхөө дагуу явж байна. Энэ тэрийг бол шүүхүүд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэмжээнд нь хэрэглээд явж байгаа.

Шүүхийн бие даасан байдал шүүгчийн хараат бус байдалтай холбоотой ойлголтууд бол манай шүүхийн хэмжээнд хангалтгүй хэрэгждэг. Өөрөөр хэлбэл хамгийн

сүүлийн байдлаар НҮБ-ын шүүгч хуульчдын асуудал хариуцсан шинжээч ирээд сар хүрэхгүй хугацааны өмнө шүүхүүдээр орсон байна, нөхцөл байдалтай танилцсан, шүүгч нартай уулзаад явсан байгаа. Энэ шинжээчийн ажиглаж байгаа байдлаас нь урьдчилсан байдлаар дүгнэлт хийхэд бол шүүхийн эдийн засгийн баталгаа талаасаа нэлээн шүүмжлэлтэй хандаж байгаа. Ажиллах нөхцөл, шүүгчийн хараат бус байдал дээр бол зайлиггүй нөхцөл байдлыг нь сайжруулж ажиллах ийм шаардлага байна гэж үзэж байгаа.

Монгол орны орчинд байршдаг онцлогоос шалтгаалаад шүүхийн шүүгчийн ачаалал харилцан адилгүй байдаг. Эх газраа бол хүн ам төвлөрсөн газраа бол хэт их ачаалалтай, орон нутагтаа бол бас дунд зэргийн бага ачаалалтай, энэ хэт их ачаалалтай газруудаар ажиллах нөхцөл энэ хараат бус байдал нь алдагдаж байна гэсэн энэ урьдчилсан байдлын дүгнэлтийг хийсэн. Энийг дагаад ажиллах нөхцөл, шүүгчийн цалин, шүүхийн ажиллаж байгаа орчин, шүүхийн байрны асуудлууд дээр бол нэлээн тийм шүүмжлэлтэй хандсан. Энэ зүйлүүдийг засах, сайжруулах шаардлагатай гэсэн ийм байдлаар бас урьдчилсан байдлаар дүгнэлтийг хэлсэн байгаа.

Шүүх явуулах тухай хуулийн хуулийг дагаад тодорхой хуулиудын өөрчлөлт орж байгаа. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бид нар санал оруулсан. Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд оруулж байгаа 2 хуулийн өөрчлөлтийн заалтыг сая бас манай гишүүд тайлбарлалаа.

Шинээр шүүх байгуулагдаж байгаатай холбоотой процессын хуулиудын нэмэлт, өөрчлөлт, өөрчлөлтүүд яригдана. Энэ бас энэ ажлын хэсэг дээр цаашаа яригдаад тодорхой болоод явах байх гэсэн ийм байдалтай байна.

13-15 онуудад шүүхийн хараат бус байдалтай холбоотой тусдаа шүүхийн хамгаалалтын асуудлыг хариуцаж байсан ийм байгууллага байгуулагдаж байсан. Энэ маань татан буугдсанаас хойш Тахарын алба татан буугдсанаас хойш бол шүүгчийн хараат бус байдал шүүхийн бие даасан байдалтай аюулгүй байдалтай холбоотой асуудлыг цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах алба хариуцаад явж байна.

Д.Цогтбаатар: Болсон уу. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Ер нь авлигын хэргийн шүүхийн асуудлаас ард түмэн айхгүй байгаа. Авлигачид бол айгаад байгаа. Авлигачид л хамгийн түрүүнд авлигын хэргийн шүүхээс айгаад байгаа шүү дээ. Эсэргүүцэж байгаа. Нүүрсний сонсголыг хамгийн их эсэргүүцэж байгаа нүүрсчид байгаа. Тэд хуулийнхантай, банк санхүүтэй, хувийн сэтгүүлчидтэй болсон байгаа. Нүүрсний хэрэгт яллагдагчаар татагдсан манай намын улс төрд нөлөө бүхий этгээдүүдтэй сэтгүүлчид хамтарсан компанитай байна. Тэд хамгаалж байна нүүрсчдийг улаан цагаан. Бүхэлдээ сүлжилдсэн байна. Энэ авлигын хэргийн шүүх нүүрсний сонсгол гээд асуудлуудаар бүх салбар энэ хатуигуудаасаа салцаагай. Улс төрийн намууд нь энэ улс төрчдөөсөө салъя АН, МАН-гүй. Хуульд байгаа бохир хуулийнхнаасаа хуулийн салбар салъя. Бохир шүүгчдээсээ шүүхийн салбар салъя. Бохир авлигажсан сэтгүүлчдээсээ сэтгүүл зүйн салбар сал.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ингээд авлигатай тэмцэх дагнасан шүүх түр хугацаагаар ч юм уу байгуулах гэж байгаа юм гэж ойлголоо. Та бүхний хариулт өгөхгүй байгаагаас нь үзэхэд бол. Гэхдээ та бүхэн хариулах ёстой шүү. Ахиад би тодруулъя.

Хэрвээ байгуулбал, байгуулаад ямар үр дүнтэй юм бэ. Та бүхэн энэ дээр яг юу гэж үзэж байгаа юм. Эрүүгийн дагасан хуулиар бол байгаа юм шиг байна тэр нь. Энийг Шүүхийн ерөнхий зөвлөл юу гэж үзэж байна, Дээд шүүхээс байгаа билүү. Дээд шүүх юу гэж үзэж байгаа юм. Анхан шатынхаа шүүгч нартаа итгэхгүй байгаа юм уу. Та нар Засгийн газар юу гэж үзэж байгаа юм. Хэр зэрэг үр дүнтэй болох юм бэ. Өмнө нь яаравчилсан бүх хуулиудыг чинь бид нар батлаад л өгдөг байсан. Танай намын бүлэг дэмжиж байгаа юм уу энийг гэсэн ийм асуулттай байна.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье.

Р.Онончимэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. 2021 оны шүүхийн тухай хуульд шинэчлэн найруулагдсан. Тэрнээс хойш 2 жил гаруйн хугацаа өнгөрөөд явж байна. Шүүхийн шинэтгэлүүд бас үргэлжлэх ажлууд ярьж байна. Хамгийн их хүндрэлтэй юм бол шүүхийн хараат бус бие даасан байдал дээр төсвийн бие даасан байдал байна гэдэг асуудлыг удаа дараа ярьж байгаа. Сая НҮБ-ын тусгай илтгэгч бас энийг тусгай илтгэл дээрээ дурдсан байгаа.

Мөн 2023 онд шүүхийн ирэх 10 жил хэрэгжих бодлогыг бид хэд тодорхойлж, төслийн саналаа Засгийн газар Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн, Улсын Их Хуралд ирүүлсэн байгаа. Мөнхбаатар даргаар ахлуулсан ажлын хэсэг явж байна. Энэ ажлын хэсэг дээр бол маршал буюу Тахарын албыг оруулахаар бид хэд бодлогын түвшинд оруулчихсан явж байгаа. Тэгэхээр энэ дээр бас Ганбат гишүүн бас анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Авлигын асуудлыг ярьж байна. Авлигын шүүх байгуулах асуудал бол шүүх байгуулах Шүүхийн тухай хуулиараа судлагдаж орж ирээгүй. Та яг зөв ойлгосон.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье, гүйцээгээд хариулъя.

Р.Онончимэг: Засгийн газар хууль санаачлагчдын хувьд санаачлагчийнхаа хувьд Их Хурлын тогтоолд энэ авлигын шүүхийг судалж оруулж орж ирэх энэ саналыг тусгаж оруулж ирсэн. Их Хурлаас батлах юм бол бид хэд хуулийн хүрээндээ судлах байх гэж бодож байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар давж заалдах журмаар анхан шатаар авлигын хэргийг, хяналтын журмаар давж заалдах гэсэн энэ процесс дээр яг тухайлж бид хэд саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд өгөөгүй. Шүүхийн шүүх байгуулах тухай хуулийг дагаж орж ирсэн хууль дээр бол хууль санаачлагчид оруулж ирсэн байгаа. Магадгүй энд хэлэлцэх эсэхийг дэмжих юм бол ажлын хэсэг дээр энэ ярих байх гэж ийм ойлголттой байна.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай байгаа юм уу Ганбат гишүүн ээ. Дээд шүүх тэгээд Энхбаяр гишүүнд бүлгийн тухай асууж байх шиг байна лээ. 3 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Ганбат шүүгчийн асуулт гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр Улсын Дээд шүүх энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хүрээнд энэ авлига албан тушаалын хэргийг харьяалан шийдвэрлэх энэ шүүхийн харьяалалд өөрчлөлт оруулах энэ асуудлыг хэлэлцээд тодорхой санал өгөөгүй. Энэ бол хууль тогтоох байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудал юм гэж үзсэн.

Ингээж шүүхийн харьяаллыг өөрчлөн тогтоох нь Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуультай зөрчилдөхгүй гэдгийг би хэлсэн. Гэхдээ хууль тогтоогч авлига, албан тушаалын хэргийг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг өөрчилсөн тусгай журмыг баталж байгаа тохиолдолд бас шүүхийн эрх хэмжээг бас эргээж хараасай гэж хүсэж байгаа юм.

Тэгэхлээр хамгийн их өөрчлөлт орж байгаа хууль Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль байгаа. Анх батлагдсанаасаа хойш их олон удаа өөрчлөлт орсон.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье.

Б.Батцэрэн: 2022 оны 6 сарын 3-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Давж заалдах болон Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээнд тодорхой хязгаарлалтууд тогтоосон байгаа. Ер нь анхан, давах шатныхаа шийдвэр, үйл ажиллагааг хянах гэж давах хяналтын шатны ийм тогтолцоо байдаг. Энэ нь бас шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдол гаргах иргэний тэр Үндсэн хуульд заасан суурь эрхтэй бас холбоотой. Ингээд доод шатын шүүхийн шийдвэрээ хянах явцад тэнд хуульд нийцээгүй шийдвэр гаргах юм бол түүнийг зөвтгөдөг ийм эрх хэмжээ байх ёстой. Харамсалтай нь энэ 2022 оны 6 сарын 3-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу тэр хууль бус шийдвэр гаргасан доод шатын шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаах ийм эрх хэмжээ байхгүй болсон.

Одоо авлигын гэмт хэргийг 2 шаттайгаар хянан шийдвэрлэх ийм тусгай журам одоо.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон гүйцээгээд өгье.

Б.Батцэрэн: Авлигын гэмт хэргийг 2 үе шаттайгаар шийдвэрлэх тусгай журам батлагдсан тохиолдолд Давж заалдах шатны шүүхэд хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэх нь байна. Энэ хэргийг Хяналтын шатны шүүх давж заалдах журмаар шийдвэрлэнэ. Ингээд энэ хэргийг буруу шийдсэн байна гэсэн ийм дүгнэлтэд хүрэх юм бол энийг хэрхэн засах вэ гэдэг ийм хууль зүйн тэр эрх хэмжээ хязгаарлагдмал болчихсон шүү.

Тэгэхлээр нэгэнт 1 үе шат ингэж хасагдаж зөвхөн 2 үе шаттай болж байгаа тохиолдолд тэр алдаатай шийдвэр гаргасан бол түүнийг зөвтгүүлэхээр дахин хэлэлцүүлэхээр буцаадаг. Энэ эрх хэмжээг сэргээн оношлох шаардлагатай, эсвэл шилжүүлсэн хэргийнх нь хүрээнд хэргийн зүйлчлэл болон ялыг өөрчилж, нэмж хүндрүүлж шийддэг эрх хэмжээг олгох шаардлагатай.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар энэ 3 жилийн судалгааны дүн гарсан. Дээр нь шүүхийн нэгдсэн мэдээнээс харахад Авлигатай тэмцэх газраас шүүхэд шилжүүлсэн нийт хэргийн 50-60 хувь нь прокурорт буцсан ийм дүн мэдээ байна. Энэ хэргийг буруу тусгаарласан, мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгдсэн, нотлох баримтыг бүрдүүлэхдээ хуульд заасан журмыг зөрчсөн. Эдгээрийг шүүхийн шатад нөхөн гүйцэтгэх боломжгүй гээд ингээд прокурорт буцаадаг шүүхийн эрх хэмжээг хүчингүй болгосноор энэ алдаа, зөрчил хэвээрээ л байгаа. Энэ алдааг шүүхийн шатад нөхөн гүйцэтгэх тэр зохицуулалтыг оруулж ирсэн. Шүүх хуралдааныг 2 сар хойшлуулах замаар.

Гэтэл нэлээн томоохон мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх, их үнийн дүнтэй шинжилгээний дүгнэлт гаргуулах хэргүүд бол энэ 2 сарын хугацаанд амжихгүй байгаа юм. Энэ хуулийн хэрэгжилтээс харахад шүүхийн даалгасан ажлыг бүрэн гүйцэд прокуророор биелүүлэхгүй ийм тохиолдлууд байна. Энэ тохиолдолд зайлшгүй хэргийг прокурорт буцаах, нэмэлт ажиллагаа хийх ингээд тэр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотолбол зохих ажиллагааг бүрэн хийсний дараа энэ гэм буруу нотлогдсон уу үгүй юү гэдэг дээр шүүх хууль зүйн дүгнэлт хийх боломжтой.

Өөрөөр хэлбэл дутуу ажиллагаа хийчихсэн байхад энэ дээр хэргийг ашигтайгаар шийдвэрлэнэ гэдэг...зарчим

үйлчлэх боломжгүй байгаа юм л даа. Тэгэхлээр Улсын Дээд шүүхээс энэ Давж заалдах болон Хяналтын шатын шүүхээс доод шатын шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаах энэ эрх хэмжээг сэргээн хуульчилж өгөх ийм саналыг удаа дараа хууль санаачлагчид хүргүүлсэн байгаа. Энийг та бүхэн анхаарч үзээсэй гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ер нь юу байна, шүүх дээрээ бид нар эдийн засгийн талаас нь анхаарах нь зүйтэй юм байна гэдэг нь харагдаж байна. Тэгээд өнөөдөр 8 жил эрх барьчихаж байна 1 нам. 62, 65 суудалтай та нар маань 8 жил амжилттай ч юм уу, амжилтгүй ч юм уу тэмцсэн байна. Би бол амжилтгүй л гэж дүгнээд байгаа юм л даа. Ард түмэн ч бас тэгж дүгнэж байгаа байх. Надтай санал нэг байгаа байх. Та нар маань бүлэг дээрээ их нууц биш бол хэлчихгүй юу даа ард түмэндээ. Энэ асуудлаа яах вэ би ард түмнийг төлөөлж байгаа болохоор бас яах вэ дээ асуугаад байна л даа мандаттай хүн тийм. Танай тэнд бол хувийн юм байхгүй байлгүй дээ. Би та нарын авгай хүүхэд тэр янз бүрийн нарийн ширийн юмыг чинь мэдэх ч хүсэл ч алга, сонирхох ч үгүй. Энэ хуультай холбоотой л юмыг асуугаад байна. Тийм Монголын ард түмэн нэг бүртэй холбоотой ийм зүйлийг тодруулж байна. Та нар.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Нэгэнт асуулт асууж байгаа юм чинь хариулалгүй яах вэ юу. Бүлэг дээр бид нар ямар нэгэн эцэслэсэн шийдвэр, нэгдсэн шийдвэр гаргаагүй байгаа. Бүлэг дээр мэдээж ярьж байгаа шүү дээ бид. Гэхдээ одоо энэ дээр эцэслэн шийд гараагүй байгаа.

Сандаг-Очир гишүүнд микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Юуны өмнө шүүх байгуулах тухай хууль орж ирж байна. Өмнө нь боловсрогдсон байсан хуулийн төсөл дээр алсын 3 дүүргийг 1 шүүх болгоод төв нь Налайхад байна гэсэн ийм хуулийн төсөл явж байсан. Энийг орон нутгийн шүүхийн байгууллагын санал, мөн орон нутгаас сонгогдсон 2 Их Хурлын гишүүний санал юмыг сонсож, харгалзан үзэж бас хүлээж авч, одоо өргөн баригдсан байгаа өнөөдөр хэлэлцэгдэж байгаа энэ хуулийн төсөлд бас өөрчлөлт оруулахгүйгээр одоогийн байдлаар нь ингээд шүүхийг тойргийн зарчмаар явуулахаар ингээд явж байгаад нь талархлаа илэрхийлье.

Учир нь гэвэл бас шүүхийн үйл ажиллагаа иргэндээ их ойрхон байх ёстой энэ зарчим алдагдчих гээд байсан. Мэдээж та бүхэн маань Шүүхийн ерөнхий зөвлөл төсөв мөнгө гээд ярьж байгаа байх. Төсөв мөнгөнөөс илүүтэйгээр шүүхийн үйл ажиллагаа аль болох ард иргэддээ ойрхон байж, зардал чирэгдэл багатай байх, амар хялбар, ойр дөт байх энэ чиглэлээр та бүхэн асуудалд хандаж оруулж ирсэн гэж ингэж ойлгож байна.

Нөгөө талаар энэ хялбаршуулсан хялбар ажиллагааны шүүхийг улсын хэмжээнд нийслэлийн хэмжээнд 1 тойргийн шүүх байхаар ингэж оруулж ирж байна. Энэ маань хялбар ажиллагааны шүүх чинь харин эргээд яг хялбар гэдэг энэ утгаа алдчих вий дээ. Энэ дээр та бүхэн хэрхэн яаж тооцоо судалгаа хийсэн. Дүүргүүдийн ер нь шүүхийн чинь бараг тэн хагас нь үндсэндээ бараг хялбар ажиллагааны журмаар шийдүүлсэн хэргүүд байдаг юм байна шүү дээ. Ганихан шүүх дээр хялбар ажиллагааны асуудлууд шүүх эрүү, иргэний асуудлууд шийдэгдэхээр эргээд энэ чинь харин хялбар зарчмаа алдаад, нэлээн төвөгтэй, нэлээн удааширалтай, чирэгдэл учруулсан байдлаар ийм шүүх болчих вий дээ. Та бүхэн дүүргийн шүүгч нарын ачаалал 30-40 хувиар буурна гэж тооцоолсон байна. Тэгвэл хялбар ажиллагааны шүүх чинь харин өөрөө

эргээд ачаалалтай шүүх болчих вий дээ. Энийг та бүхэн юу гэж харж байна.

Нөгөө талаар бас энэ алсын 3 дүүргийн хялбар ажиллагааны шүүх бас нийслэл дээрээ л ирэх нь л дээ. Тэгэхээр бас энэ 2 дүүргийн хувьд бас энэ асуудал, энэ хэрэг маргааны асуудлууд бас энэ зарчим алдагдаж бас нэлээн төвөгтэй болох нь л дээ. Энийг та бүхэн юу гэж харсан бэ гэдгийг хоёрт асууя.

Гуравт, би энэ гишүүд энэ хуулийг уншихаар өргөн баригдсан Шүүх байгуулагдах хууль ерөөсөө энэ авлигын хэргийн асуудал ерөөсөө огт хөндөгдөөгүй байгаа байхгүй юу. Дагасан Улсын Их Хурлын тогтоол дээр 24 ондоо багтааж Засгийн газарт энэ асуудлыг судалж оруулж ирэх асуудлыг л үүрэг болгосон тогтоол байгаа юм. Тэрнээс өнөөдрийн өргөн баригдсан хуульд ямар ч авлигын хэрэгтэй холбогдсон дагнасан шүүх байгуулах асуудал энэ өргөн баригдаж байгаа Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд огт яригдахгүй байгаа, асуудал хөндөгдөөгүй байгаа.

Цаашидаа сая сайдын тайлбар юмнуудаас сонсоход одоогийн байгаа тогтолцоо чинь ер нь авлигатай тэмцэх энэ асуудал яагаад үр дүнд хүрэхгүй байна вэ гэж шүүхийн тогтолцоондоо байна уу, шүүгчдээ байна уу, хуульдаа байна уу. Энийг гэж дүгнэж байна вэ. Үнэхээр одоогийн байгаа энэ тогтолцоогоороо явахаар үнэхээр энэ авлигатай тэмцэх асуудал дээр ахиц гарахгүй байна гэж үзэж зайлшгүй дагнасан авлигын шүүх байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа юм уу. Хэрвээ дагнасан шүүх байгуулна гэж үзвэл та бүхэн яаж авлигатай тэмцэх ажил дээр яаж үр дүн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Тодруулах уу, гүйцээх үү асуултаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Хэчнээн авлигатай тэмцэх дагнасан шүүх байгууллаа гээд

шүүгч нар маань өөрсдөө хууль, хүчний байгууллагууд маань өөрсдөө энэ тал дээр үнэхээр илрүүлчихье гэдэг байдлаар ажиллахгүй бол энэ сүлжээ юманд нь холбогдоогүй байвал мөн шүүгч нарын бие даасан байдал шүүхийн хараат бус байдал нь хангагдаад ажиллаж байгаа бол одоогийн байгаа тогтолцоогоороо ч авлигатай тэмцэх ажил дээр явах явдгаараа л явна.

Гэтэл заавал дагнаж байгуулж байгаа нь ямар хэрэгцээ шаардлага байна вэ. Энийг юу гэж үзэж байгаа юм бэ. Ямар ахиц өөрчлөлт гарна гэж үзэж байгаа юм бэ. Энэ дээр та бүхэн хариулт өгөөч. Сайд уу, хэн өгөх юм.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайдад микрофон өгье.

Б.Энхбаяр: Ер нь сүүлийн жил гаруй бол маш олон том томоохон авлига албан тушаалын хэргийг Засгийн газар өөрөө Улсын Их Хурлын дэмжлэгтэйгээр шүүхэд хүлээхийг нь хүлээж, нээлттэй болгохыг нь нээлттэй болгож, шалгахыг нь шалгаж, мөрдөх албад хяналтын журмаар ч тэр, шүүхийн журмаар ч тэр эхнээсээ шийдвэрлэгдэж явж байна л даа.

I томоохон авлигын хэргийн цаана олон хуулийн байгууллага, олон хүний хүч хөдөлмөр байдаг. Нууц, далд аргаар илрүүлдэг, том мафитай нүүр тулдаг. Яг ял оногдуулж байгаа байдалд нь анхан шатын шүүхүүдийн энэ сүүлийн үеийн байдалд харахад үнэхээр итгэл бас алдарч байна. Бид нар энэ Баттулга гэж хүний тавьсан тэр Мөнхбаяр гээд Хөдөлмөрийн баатар Хөгжлийн банкин дээр ярьсан шүү дээ. Илрүүлсэн. Тэр хүнийг гаргаад явуулчхаж байгаа юм. Хэдэн 10 тэрбум төгрөгөөр нь мөнгө аваад, бэлнээр аваад мөнгө угаачихсан хэрэг байхгүй. Дараа нь тодорхой хээл, хахуулийн хэрэг яриад байгаа шүү дээ 2.7 тэрбум төгрөгийн хахууль. Тэгээд 20 сая төгрөгөөр торгоод явуулчхаж байна шүү дээ.Тэгээд яах юм. Итгэхийг хүсээд байна шүү дээ. Шүүхдээ итгэхийг хүсээд

байгаа байхгүй юу. Би бол сүүлийн 1 сар энэ Шүүхийн хууль ч тэр, энэ улсын төсөв ч тэр дандаа шүүх эрх мэдлийг хамгаалахын төлөө энд нөлөөлж болохгүй тухай ярьж байгаа. Шүүх дээр явж байгаа 1 ч хэргийн талаар би шүүх байгуулагдсан хууль батлагдсанаас хойш 1 ч байр суурь илэрхийлэхгүй байгаа. Шалгагдаж байгаа юм уу, шүүх дээр явж байгаа тодорхой хэрэг учралын талаар.

Энэ нь яагаад байна вэ гэхээр шүүх эрх мэдлийг бас улс төрийн нөлөөлөх, өөрөө улс төрд нөлөө бүхий этгээд болчихоор чинь бас нөлөөлөл болчих вий. Үгүй аминдаа хараад л байгаад байгаа байхгүй юу. Хөгжлийн банкны сонсголыг хийчхээд Хөгжлийн банкны энэ шүүхийн шийдвэрүүд дээр юу гэж бодож байна гэж надад коридорт миний аманд маш олон сэтгүүлч микрофон зоосон. Би огт байр сууриа илэрхийлэхгүй.

Яагаад гэхээр энэ хэрэг чинь дуусаагүй байгаа байхгүй юу. Давж заалдах шаттай, Хяналтын шаттай. Дуусаагүй байгаа учраас байр суурь маань нөлөөлөл болчих вий гэж л бодоод байгаа болохоос биш тэр шийдвэр дээр бас энэ чинь бүтэн жил энэний шалгасан хүний хувьд бас энэ чинь дотор байгаа бодол бол байж байгаа шүү дээ. Энэ таслан шийдвэрлэж байгаа энэ анхан шатын шүүхийн шийдвэрүүд чинь үнэхээр ард иргэдийн итгэл, цөхрөлийг бараадна шүү дээ. Тэгэхээр одоо яах вэ. Хууль тогтоогчоор шийдэх ёстой байхгүй юу.

Яагаад гэхээр шүүх байгуулах хуулийг батлах эрх нь Үндсэн хуульд заачихсан байгаа байхгүй юу Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байгаад байгаа байхгүй юу. Гүйцэтгэх эрх мэдэлд шууд энэ чинь шүүхийг энэ чинь ингэж байгуулна тэгж байгуулна гээд өөрчилж чадахгүй шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулиар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал. Тийм учраас Улсын Их Хуралдаа энэ тогтоолын төсөл өргөн

барьчхаад суугаад байгаа царай маань ердөө л энэ л дээ.

Д.Цогтбаатар: Пүрэвдорж гишүүний микрофоныг. Пүрэвдорж гишүүний асуулт. Аан за хариулт хэн билээ 2 дугаар микрофон.

А.Насандэлгэр: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ Шүүх байгуулах тухай хуулийн нэг онцлог бол нийслэлийн хэмжээнд дүүргийн Эрүү, Иргэний хэргийн Хялбар ажиллагааны шүүхийг тойргийн зарчмаар шинээр байгуулъя гэсэн ийм шинэ шүүхийг бид нар судалгаанд үндэслэж оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаа хэргүүд, зөрчлийн хэргийг энэ дээр иргэний хэргийн 11 сая төгрөгийн үнийн дүн хүртэлх энэ нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлүүлэхээр харьяалуулж энэ шүүхийг байгуулъя гэсэн ийм төслийг бол өргөн барьсан. 18-22 оны буюу 5 жилийн байдлаар нийслэлд шийдвэрлэж байгаа нийт зөрчлийн хэргийн 20 хувь нь нийт шийдвэрлэж байгаа зөрчлийн хэргийн 20 хувийг нь нийслэлд шийдвэрлэж байна.

Тэгэхээр зэрэг нийслэлд шийдвэрлэж байгаа зөрчлийн хэрэг тэр чигээрээ энэ шинээр байгуулагдаж байгаа шүүхийн харьяалалд очно. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хэрэг 18 хувийг нь нийслэлийн хэмжээний дүүргийн шүүхүүд шийдвэрлэж байгаа юм байна. Энэ хэмжээгээр энэ шинэ шүүх дээр ачаалал очно. Иргэний хэргийн тэр үнийн дүнтэй ба бид нарын энэ томъёолж байгаагаар бага үнийн дүнтэй гэж нэрлээд байгаа хэргийг энэ хэргийн 50 гаруй хувийг нь нийслэлийн дүүргийн шүүх шийдвэрлэж байгаа юм байна. Ийм ачааллыг дундажлаад үзэхээр 30-40 хувь нь энэ шинэ байгуулагдаж байгаа шүүх дээр очих юм байна. Энэ шинээр байгуулагдаж байгаа шүүх нь хэргийн ачааллаасаа хамаараад 21 шүүгчтэй байхад үйл ажиллагаа явуулахад

ачааллын хувьд бол бусад шүүхтэйгээ бас ойролцоо ачаалалтай байж ажиллах боломжтой юм байна гэсэн ийм судалгаа гаргасан байгаа.

Захын 2 дүүрэг буюу Налайх, Багахангай, Багануур дүүргийн шүүхийн тухайд мөн харьяалал нь дүүрэгт хамаарч байгаа учраас яг энэ харьяаллынх нь дагуу яг энэ шинэ байгуулагдаж байгаа шүүх рүү энэ саяын харьяалуулж байгаа хэргүүд орж ирэх юм байна гэсэн ийм зүйлээр явж байгаа. Яг Сандаг-Очирын гишүүний болгоомжилж байгаа тэр тэнд байгаа ачаалал багасах, тэнцвэр, зарчим алдагдах ийм юмнууд гарахыг нь үгүйсгэхгүй. Тэгээд яг энэ асуудлаар бол ажлын хэсэг дээр бас тодруулж ярих, харьяаллыг нь авч үлдээх ийм зүйлүүд дахиад яригдах боломжтой гэж ойлгож байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Харин тийм. Би яг хялбар ажиллагааны журмаар алсын 2 дүүргийн асуудлыг өөр өөр дээр нь одоогийнх нь журмаар үлдээж өгөөч. Ингэвэл үйл ажиллагаа нь илүү иргэндээ ойрхон, амар хялбар байх, ойр байх энэ зарчим нь хэрэгжих юм л гэж ийм санал гаргах гээд байгаа юм. Яах вэ хэлэлцүүлгийн шатанд бас асуудлаа албан ёсоор гаргая. Та бүхэн маань бас гишүүдийг бас дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: 2020 онд Эрүүгийн хуульд өөрчлөлт ороод энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх энэ хуульд өөрчлөлт ороод бас яг ялтан болон бусад этгээдүүдийг холбогдох этгээдүүдийг шүүхийн шийдвэрийн бичгийн хамт шийдвэрийн хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэж өгнө өө гэсэн ийм заалтыг нэмсэн. Тэрнээс өмнө ямар байсан бэ гэхээр 2019 онд

гэхэд л 400 гаруй хүн оргон зайлсан, аль эсвэл байхгүй тэр хүмүүсийн шийдвэрийг түдгэлзүүлсэн ийм тоотой байсан юм. Тэгэхээр энэ бол их том тоо л доо. Тухайн үед 3150-аад ялтанд хяналт тавьж байсан үед бол энэ 400 гэдэг тоо бол их тоо байхгүй юу даа.

Энэ хуулийн өөрчлөлт орсноос хойш нийтдээ өнөөдрийн байдлаар 24000 ялтан болон албадлагын арга хэмжээ авч байгаа хүмүүст хяналт тавьж байгаа юм байна. 24000 бараг 8 дахин өссөн байна шүү дээ. Тэгэхээр энэ тохиолдолд шүүх яах вэ нэг талаасаа хэрэг шийдвэрлэх тийм бас өргөдөл, гомдол өгч байгаа хүмүүсийн шаардлага байгаа байх. Шийдвэрээ явуулдаг.

Гэтэл тэр нь холбогдогч этгээд байхгүй байж байхад нь шийдвэрлээд явуулчихдаг. Үүнээсээ болоод тэр оргон зайлах болон хаяг дээрээ байхгүй, аль эсвэл гадаадад оргоод явчихсан тэр хүмүүсийн асуудал гарч ирээд байгаа юм. Энийг 2020 оны 1 сард Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулсны дагуу энийг шийдвэрлэсэн байгаа. Гэтэл энэ дээр дахиад амраа бодоод шүүхийн шийдвэрийг тэр заавал ялтан болон албадлагын арга хэмжээ авч байгаа тэр холбогдогч этгээдтэй байхгүй байж байхад өгөхөөр ийм зохицуулалт орж ирж байгаа нь дахиад бид нарын арай гэж хийсэн тэр шийд, хуулийн зохицуулалтаас буцчихаж байна л даа. Энэ хуулийг яг тухайн үед баталж байсан 3 хүн л байна. Энэ Цогтбаатар гишүүн, Мөнх-Оргил гишүүн бид 3 тухайн үед нэлээн л явдал болж байж л энэ хуулийг баталсан юм.

Өнөөдөр ингээд нэг байгууллага нь өөртөө тохиолдож байгаа проблемыг нөгөө байгууллага руу та нар юманд унана гэдэг байдлаар асуудлыг ингэж нөгөө байгууллагуудаасаа санал авахгүйгээр ингээд дураараа оруулж ирж ерөөсөө болохгүй шүү дээ. Энэ байгууллагаасаа бас санал аваагүй, дээрээс нь энэ яам нь яагаад тийм ямар учиртай хариу өгсөн юм. Дэмжсэн хариу

өгссөн болоод энэ асуудал орж ирж байгаа шүү дээ. Юман дээрээ сайн анхааралтай Энхбаяр дарга ажиллаж байгаа юм уу сайд. Та энэ дээр бас тодорхой хариулт өгөөрэй. Би энэ заалтыг дэмжихгүй байгаач гэж би гишүүдээсээ хүсэж байгаа юм.

Энэ бас энэ өөрөөр хэлбэл энэ чинь 24000 ялтан болон албадлагын арга хэмжээ авсан тэр хүмүүс дээр хяналт тавьдаг, тэгээд хүн хүчний хувьд хангалттай биш ийм байгууллагыг ингээд дахиад л баахан шүүхийн шийдвэр нь холбогдогч этгээдгүй баахан шийдвэр л явуулаад байдаг. Тэгэнгүүт буцаагаад нөгөө байгууллага нь би үхэхээр та нар үх гэдэг байдлаар асуудалд ингэж хандаж бүүр ерөөсөө болохгүй байхгүй юу. Энэ асуудлаа та нар хоорондоо ярилцах ёстой байхгүй юу. Заавал энэ Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний байцаан шийтгэх тэр хуулиудад өөрчлөлт оруулахгүйгээр хоорондоо энэ ажил хэргийн уулзалт хийгээд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Нэмэлт гүйцээгээд асууя. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тийм хоорондоо харилцан тийм ажил хэргийн уулзалтуудыг хийх ёстой. Тэр нь бараг хийгдээгүй юм байна. Та тэр байгууллага ингэсэн, энэ байгууллага ингэсэн гэдэг байдлаар сая хариултаас харагдаж байна шүү дээ. Тийм учраас энэ заалтыг Их Хурлын гишүүдийг дэмжихгүй байгаад дахиад энийгээ дотроо тэр уулзалтаа зохион байгуулаад, дахиад өөр ямар арга хэрэг хуульд аль аль нь хамтраад энэ оргон зайлах тэр нөхцөлийг гаргахгүйгээр ямар өөр боломжууд байна. Аль альдаа боломжтой тэр хувилбараар нь оруулж ирэхийг хүсэж байна. Энэ дээр бас тодорхой хариулт авъя. Гишүүдийг дэмжихгүй байхыг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Эхлээд Хууль зүйн сайдыг.

Б.Энхбаяр: Би гишүүдийн хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Тийм, дагасан хуулийн I заалт дээр би түрүүн Мөнх-Оргил гишүүний бас асуултад хариулахдаа хэлсэн. Ер нь ялангуяа энэ хууль шүүх байгууллагуудын хэрэглэдэг ийм хуулиуд дээр хуулийн байгууллагууд санал нэгдэж орж ирнэ гэдэг юм байдаггүй юм угаасаа. Мөрдөгч байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага. Бид хууль тогтоогчид шүү дээ. I байгууллагын амбиц гэдэг юм уу тайлбарыг ганцхан хөтлөгдөж лоббид өртөлгүйгээр асуудлыг олон талаас нь яриад тэр зөв шийдлийг нь гаргах нь л хууль тогтоогчийн гол ажил байгаа.

Тийм учраас хэлэлцүүлгийн шатад энэ асуудлаа дэмжихээд, би бол хатуу байр суурьтай биш байгаад байгаа байхгүй юу. Хууль санаачлагч өөрөө тийм л хатууран мугуйд энэ нь л зөв гэдэг тийм туйлын хатуу байр суурьтай биш байгаа байхгүй юу. Энэ дээр бол шүүх байгууллагууд, прокурор, шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тооцоо, үндэслэл, мэдээ материалыг ажлын хэсэг дээр яриад илүү зөв шийдлийг гаргах би бололцоотой гэж үзээд байгаа байхгүй юу. Энэ дээр бол бас Пүрэвдорж гишүүн урьд нь бас энэ дээр тодорхой ажил хэрэгчээр оролцсон, энэ ажлын хэсэгт бас оролцоод бас энэ хүрээндээ бас шийдэл гаргаад явахад хууль санаачлагчийн хувьд миний хувьд тийм уян хатан байр суурь баримталж ажиллана гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: I дүгээр микрофон.

Б.Ундрах: Баярлалаа. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ерөнхий зөвлөлийн гишүүн Ундрах байна. Тэгэхээр хамтарч ажиллах асуудал хууль хэрэглээний хувьд бид нар энэ асуудлыг шийдэх гэж үзсэн. Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл, цагдаагийн байгууллага, Шийдвэр гүйцэтгэл, Хууль зүйн яамтай хамтраад бид нар Хууль зүйн яаман дээр

энэ талаар ярилцсан. Үе үеийн Ерөнхий зөвлөл энэ талаар ярьж байсан юм байна лээ. Энд албадлагын арга хэмжээний тухай яриагүй байгаа. Бид нар хорихоос өөр төрлийн ялын тухай л ярьж байгаа. Албадлагын арга хэмжээ бол асуудалгүй.

Яагаад гэвэл цагдаагийн байгууллага өөрөө хүнээ авчраад, асуудлаа шийдүүлээд, хүнээ аваад явчихдаг. Тэнд бол алга болох тийм тохиолдол манайд бүртгэгдээгүй, манай судалгаанд байхгүй.

Дараагийн асуудал нь энэ хүнтэй нь авах энэ асуудлыг бид нар шууд өөрчилж гэдэг санал гаргахгүй байгаа. Хуулийн зохицуулалтыг нь яг хэвээр үлдээгээд нэмэлт оруулъя гэсэн санал байгаа. Өөрөөр хэлэх юм бол эхлээд бид нар хүнтэйгээ аваачих хуулийн заалтыг нь л үлдээе гэсэн саналтай байгаа юм. Шүүх бол аль болохоор хуучин заалтын дагуу хүнтэйгээ аваачих ийм асуудлыг шийднэ. Алга болсон тохиолдолд яах вэ л гэдэг асуудал байгаа юм. Хэрвээ хүн нь олдохгүй, шүүх өөрөө ийм эрх мэдэл бүхий биш захирамж гаргах ийм хуулийн зохицуулалт байхгүй байгаа тохиолдолд ямар ч байсан үнэхээр энэ хүн чинь олдохгүй юм байна гээд аваачиж өгөх асуудал л энд ярьж байгаа. Тэгэхээр шүүх бол өөрөө тогтоолоо хүнтэй нь аваачих ийм хуулийн заалт бол хэвээрээ байгаа шүү. Тэгээд энэ асуудал биелэгдэхгүй бол дараагийн асуудал яригдана гэдэг утгаар нь хуулийн өөрчлөлтийн санал оруулсан байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асуулаа. Би хэдэн асуулт асуучихмаар байна.

Нэгдүгээрт, энэ яах вэ ер нь Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол ерөнхийдөө энэ ярих ёстой чухал асуудлуудын нэг. Тийм учраас зарчмын хувьд энэ асуудал нь бол зөв. Энэ дээр хэдэн асуулт хууль санаачлагчид байгаа юм. Жишээлбэл энэ дагалдаж орж ирж байгаа хуульд

авлигын шүүхийн асуудал яг тэр үгээрээ байхгүй ч гэсэн гэхдээ энэ тогтоолд энийг судалъя гэж орж ирж байна шүү дээ. Тэгэхлээр үүнтэй холбогдуулаад би ийм асуулт асуумаар байгаа юм. Түрүүн Энхбаяр сайдын юун дээр чинь гарч байна энэ авлигын шүүх байгуулахгүй бол бас болохгүй байгаа юм гээд. Тэн дээр авлигын шүүх маань өөрөө авлигажихгүй гэсэн баталгаа ер нь хаана байгаа вэ.

Яагаад гэвэл тэр авлигын шүүх гэдэг үг хэрэглэгдсэнээс болоод тэр шүүх авлигажих вий. Хэрэв авлигын асуудал хэлэлцээд тэр шүүх авлигажиж байгаа бол тэгээд шүүгчид авлигажиж байгаа бол тэр нэрийг нэмлээ гээд тэр эрсдэл алга болохгүй шүү дээ. Харин ч бүүр энийг шийддэг хүмүүсийн тоог хязгаарлаад өгөхлөөр авлигачдад хэнтэй ажиллах вэ гэдгийг нь бүүр нарийвчлаад заагаад өгчих юм биш биз дээ. Шүүх бүрэлдэхүүнийг бүгдийг нь худалдаж авна гэдэг бол энэ их том шүүх бүрэлдэхүүн чинь аягүй хэцүү шүү дээ. Та нарт ийм шүүх байгуулаад өгчихлөөр цөөн тооны хүнийг ёстой эрх мэдэлтэй хүмүүс эртнээс танилцаад, онилоод тийшээ ажиллаач гэдэг чиглэл өгчхөж байгаа юм биш биз дээ. Өөрөөр хэлбэл тэр авлигын шүүх авлигажихгүй гэсэн баталгаа хаана байх вэ.

Хоёр дахь асуудал нь энэ авлигын хэрэг дээр Давах шатны шүүхээс энэ Анхан шатны шүүх ажиллагаа явагдаж эхэлнэ гээд тэгж байна л даа. Тэгэхлээр энэ дээр Хүний эрхийн комиссоосоо санал авсан уу. Энэ чинь нээрээ хүний эрхийн зөрчил гарах тэр эрсдэл байгаа юм биш биз дээ. Тэр Хууль зүйн сайд түрүүн ийм юм хэлж байна л даа энэ ахиад тэр авлигын шүүхтэй холбогдуулаад авлигын шүүх байгуулах нь яагаад ач холбогдолтой гэдэг дээр ингэж байна шүү дээ шүүгчид хоцрогдчихоод байгаа юм аа, авлигын шүүх авлигын хэрэг чинь аягүй нарийн учраас энэ дээр их боловсронгуй мундаг шүүгчид тавих нь л дээ. Энэ бол ноцтой юм ярьж байна шүү.

Яагаад гэвэл ердийн иргэдийг дутуу мэдлэгтэй шүүгчээр хэргийг нь шүүлгэх гэж байгаа юм уу. Эрх мэдэлтнүүдийг болохлоор илүү нарийвчилсан нарийн мэдлэгтэй, иргэд дээр ч гэсэн шүүгч хүн өөрөө энэ асуудлаа дээд хэмжээнд мэддэг сайн боловсорсон хүн байх ёстой. Түүнээс иргэн дээр арай хоцрогдчихоод байгаагаа тавиад, эрх мэдэлтнүүд дээр арай сайныгаа тавих гэж байгаа ийм логик гарах гэж байгаа бол наадах чинь ёстой ноцтой ялгаварлан гадуурхсан асуудал чинь гарч ирнэ шүү дээ. Тэгэхлээр ийм юм байхгүй юм байгаа биз дээ. Энэ орж ирж байгаа нь зүгээр судалъя гэж дагалдах юугаар орж ирж байгаа болохлоор энэ ерөнхий том асуудал маань зарчмынхаа хувьд би зөв байх гэж бодож байгаа юм. Энэ 3 асуултад хариулт авъя.

Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Сүүлийн үед энэ илэрч шалгаж байгаа томоохон хэргүүд бол үнэхээр энгийн ухамсраар ойлгоход төвөгтэй санхүүгийн механизаци хийж байгаа юм. Арваад жилийн өмнө үнэт цаасны төлбөр тооцооны даргаар ажиллаж байсан хүнийг Анхан шатын шүүх жишээлбэл мөнгө угаах гэмт хэргээр яллаж байгаад Давж заалдах шатын шүүхээр гэмт хэрэг биш байна гэж цагаатгаж байсан. Энэний шалтгаан нөхцөлийг судлаад үзэхэд анхан шатын шүүх нь олон улсын бирж дээр үнэт цаас арилжаалахтай холбоотой санхүүгийн мэддэг мэдээлэл байхгүй байсан. Энэ арилжиж байгаа, үнэт цаасаа зарж байгаа, худалдаж авч байгаа үйлдлийг нь мөнгө угаах гэдэг гэмт хэргээр зүйллээд прокурор нь яллах дүгнэлтээ үйлдээд, шүүх нь яллагч байсан. Давж заалдах шатын шүүхээр энэ гэмт хэрэг биш гэж үзээд сүүлдээ тухайн яллаж байсан этгээдээрээ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулаад шүүгч нартаа сургалт оруулж байсан. Үнэт цаас гэж юу юм, олон улсын хөрөнгийн бирж дээр арилжих гэдэг чинь юу юм, зарах гэдэг

чинь юу юм, энэ яаж явагддаг юм гэдэг асуудал яригдаж байсан.

Өнөөдөр анхан шатын шүүх дээр Эрдэнэтийн 49 хувьтай бүлэг зохион байгуулалттай гэмт үйлдэл шүүх дээр оччихоод байж байгаа. Энэ үйлдэл чинь үндсэндээ 3 тэрбум ам.доллар буюу 10 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий улсын өмчийг, байгалийн баялгийг хэдэн нөхдүүд Ерөнхий сайдтайгаа оролцоод, сайд нар нь оролцоод, банк санхүүнүүд нь оролцоод, хуулийнхан нь оролцоод механизаци хийгээд авчихсан ийм асуудал байхгүй юу. Үндэстэн дамначихсан. Хүн ойлгохооргүй санхүүгийн схемтэй. Монголбанк нь татан орогдчихсон, Цэцийн гишүүд нь татан орогдчихсон. Энэ чинь ийм ердийн биш хэргүүд байгаа байхгүй юу. Энийг ердийн хэрэгтэй адилтгаад байх юм байхгүй. Ийм үйлдлийг болохоор би өөрөө энэ 49-ийн дэд сайд байхдаа энэ шалгах ажлын хэсгийн чинь дэд ажлын хэсгийн ахлагч байсан байхгүй юу. Энэний схем бол ер нь хүн ойлгоход аягүй төвөгтэй схем шүү дээ. Зүгээр хараад ойлгохгүй энийг чинь. Мааш их, би хэлээд байна шүү дээ ухаантай гэж би хашилт дотор хэлээд байгаа байхгүй юу. Яг харангуут тийм яг хуулийн дагуу. Одоо нүүрсний хэрэг дээр яг ийм механизаци танилцуулагдах гэж байгаа. Яг энэ хуулийн заалтыг шууд зөрчсөн үү гэхээр шууд зөрчөөгүй. Тэгэхдээ яг тэр компанид зориулаад л механизаци хийчихсэн тэрнийх нь цаана хэдэн тэрбум доллар утсан ийм л асуудлууд байгаа байхгүй юу. Энэ ердийн хэргүүд биш байхгүй юу. Одоо энэ илрээд байгаа шүүх дээр очоод байгаа хэргүүд чинь.

Тийм учраас энийг нарийн мэргэжсэн, илүү мэргэжсэн, зүгээр гэр бүл, хүүхдийн асуудал шийддэг шүүгч шийдэх ийм шүүгчээр шийдүүлээд ийм бид авлигыгаа ялна гэж бодох боломжгүй болчихоод байгаа юм л даа.

Д.Цогтбаатар: Тэр авлигын шүүх авлигажихгүй гэдэг баталгаа Хүний эрхийн комиссоос саналаа авсан уу. Энэ

2 шаттай болгох гэж байгаатайгаа холбогдуулаад гээд тэн дээр хэн хариулах вэ ажлын хэсгээс. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Ер нь авлигатай хатуу тэмцье гэдэг бол Засгийн газар, Ерөнхий сайдын улс төрийн хатуу байр суурь, бодлого байгаа. Энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхээс санал ирээгүй. Энэ бол Засгийн газрын бодлого байгаа.

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлэх гишүүд саналаа өгье. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Оруулж ирсэн хуулийн төслийг дэмжиж байгаа, хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа. Хэлэлцэх эсэхийг нь дэмжсэний дараа нэгдсэн хуралдаанаар орсны дараа ажлын хэсэг байгуулж нэлээн нарийн, нухацтай ярих хэрэг гарах байх. Нэлээн зардал мөнгөний асуудал энд яригдаж байна. Энэ зөвхөн шүүгчдийн орон тоо хүнтэй холбоотой 47 тэрбум, байр савтай холбоотой 240 хэдэн тэрбум гээд нэлээн их мөнгө яригдаж байгаа байхгүй юу. Энэ хэдийг хэдүүлээ бас Төсвийн байнгын хороотойгоо, Засгийн газрын сайд, дарга нартайгаа тал талаас нь ярих асуудал байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газар, Ерөнхий сайдын авлигатай тэмцэх тэмцлийг дэмжиж байгаа. Их Хурлаас энд ямар дэмжлэг, туслалцаа үзүүлж болохоор байна. Улсын Их Хурал тэр дундаа Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн Байнгын хорооны хувьд бол бүрэн дэмжиж ажиллахад бэлэн байгаа. Их Хурлаас уг нь заавал Засгийн газарт судал гэдэг чиглэл өгөх хэрэггүй л юм байгаа юм л даа. Өөрсдөө судлаад л оруулаад ирвэл шууд оруулаад ирэх л юм байгаа юм. Энэ асуудлаа нэг тийш нь болгоно биз. Энд дагнасан шүүх байгуулж байгаа нь, байгуулах санал орж ирж байгаа нь сайшаалтай ч гэсэн миний бодлоор шүү, миний бодлоор

хөдөлмөрийн маргааны асуудлууд, татвар, гааль, санхүүгийн үнэт цаасны эрх зүйтэй холбоотой нарийн мэргэжил шаардсан шүүхийг жишээ нь дагнуулмаар байгаа байхгүй юу.

Гэр бүл, хүүхдийн эрхийн дагнасан шүүх байгуулахдаа энийг нийслэлд зүгээр давж заалдах шат шатаар байгуулчихад л надад болмоор санагдаад байгаа юм. Хэрвээ үнэхээр яг дагнасан шүүх байгуулах гээд байгаа бол. Тэгэхээр нийслэлд заавал анхан шатны ийм шүүх байгуулж бас иргэдэд хүндрэл учруулахын оронд анхан шат дээрээ ердийн журмаараа шийдээд, дагнах дээрээ нийслэл дээр ирдэг, хөтөлбөрийг ч гэсэн нийслэл дээрээ давж заалддаг байхад болохоор байгаа юм.

Процессын хувьд их сонин юм болчихоод байгаа юм л даа. Энэ өргөн барьсан хууль дээр бид нар Улсын Их Хурал хууль тогтоох эрхийнхээ хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулаад бид нар өөрсдийнхөө хүссэнээр янзлаад баталчхаж болно л доо.

Гэхдээ энэ чинь шүүх байгуулах асуудал учраас яг Ерөнхий зөвлөл, Засгийн газраас өргөн барьснаас нь бас их хол хөндийрүүлж болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхлээр ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг дээрээ нэлээн цаг гаргаж олон талаас нь ярьж байж ахиад хэдэн жил тогтвортой үйлчлэх шүүхийн бүтцийг л нэгмөсөн бий болгомоор байгаа юм. Бүхэлд нь асуудлыг хэлэлцэхийг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Би бас товчхон ганц зүйл хэлчихье. Энэ сая Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас бас тавиад байгаа саналыг та нар маань тал талдаа энэ ажлын хэсэг байгуулагдаад асуудал хэлэлцэж байхдаа яриарай. Тэгэхгүй та нар маань энд орж ирчхээд Байнгын хороон дээр энд яриад байх. Тэгэхлээр уг нь энийгээ ярьчхад орж ирэх ёстой байсан.

Гэхдээ ажлын хэсэг дээр энэ бас нэг нэгэндээ энэ тавьж байгаа асуудалдаа хүндэтгэлтэй хандаад нэг салбарынхан юм чинь та нар нэг л зорилгын төлөө явж байгаа. Тэгэхлээр энэ асуудлаа эргээж харж, сайн судалж ярилцаарай нэг.

Хоёр дахь хэлэх зүйл энэ авлигын асуудлаар дагнасан шүүх байгуулна гэдгийг яг үгээрээ оруулж ирээгүй, судалъя гэж оруулж ирж байгаа ч гэсэн энэ дээр энэ дагалдаж орж ирж байгаа юун дээр болохлоор энэ 24 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 25 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл энэ үргэлжилнэ гэдэг чинь бүүр аягүй тодорхой цаад агуулгаараа бүүр байгуулна. Тэр болтол энэ чинь үйлчилнэ гээд заагаад байна шүү. Энэ яахлаараа энэ 25 оныг хүртэл хэргүүд чинь гацаад, шийдэгдэхгүй болоод явчих юм биш биз дээ. Энэ юмнуудаа бас судалж үзээрэй. Тэгэхгүй бол энд чинь ийм ойлгомжгүй асуудлууд байгаад байна шүү.

Ерөнхийдөө энэ шүүхийг байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын асуудал зарчмын хувьд энэ зөв. Бид нар энийгээ ярих ёстой. Сүүлд энэ нэмэлт ороод ирчихсэн асуудлууд чинь жоохон эргэлзээ, зөрчил, үзэл бодлын зөрчил төрүүлээд байна шүү дээ.

Гэхдээ энийгээ нэгэнт бид нар хэлэлцэх эсэхээ шийдчихээд, ил тод хэлэлцээд ярилцаад явах боломж нь нээлттэй байгаа. Ажлын хэсэг энэ дээр сайн ажиллана биз.

Ингээд гишүүд үгээ хэлж дууслаа. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

90хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

14.37 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР